



International
Labour
Organization



ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER
ЭДИЙН ЗАСГИЙН БОЛЛОГО, ОРСОЛОДХ
ЧАДВАРЫН СУДЛГААНЫ ТӨВ

МОНГОЛ УЛС ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙРНЫ ЗУРАГЛАЛ

Улаанбаатар 2014



Partnership for Action on
GREEN economy PAGE

- Төслийн нэр:** Ногоон эдийн засгийн төлөө түншлэл – Нэгдсэн үндэстний байгууллагын (НҮБ) салбар байгууллагууд болох НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын Үйлдвэрлэл хөгжлийн байгууллага, НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэнгийн хамтарсан төсөл
- Судалгааны ажил:** Монгол Улс дахь Ногоон ажлын байрны зураглал
- Гүйцэтгэгч:** Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ)
- Судалгааны баг:**
- | | |
|-------------|-----------------------|
| Б.Лакшми | /Ерөнхий захирал/ |
| И.Одончимэг | /ЭЗБӨЧСТ-ийн менежер/ |
| С.Байгалмаа | /Зөвлөх/ |
| С.Хандсүрэн | /Зөвлөх/ |
| А.Болдсүх | /Зөвлөх/ |
- Хаяг:** Сан бизнес центр, 9-р давхар
Ерөнхий сайд Амарын гудамж 29
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол Улс
- Утас:** (+976) 11-321927
Факс: (+976) 11-321926
И мэйл: info@ecrc.mn
Вебсайт: www.ecrc.mn

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ДДНХБ	Даян дэлхийн хөгжлийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХБОСХ	Дэлхийн хүрээлэн буй орчны стратегийн хүрээлэн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МАОЭНХ	Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МЗН	Монголын Зөгийчдийн нийгэмлэг
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МҮХАЙТ	Монголын Үндэстний худалдаа, аж үйлдвэрийн танхим
МҮЭХ	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо
НД ТББ	Ногоон дэлхий төрийн бус байгууллага
НҮБХБОБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүрээлэн буй орчны хөтөлбөр
НҮБҮХБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үйлдвэр хөгжлийн байгууллага
НҮБССХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Сургалт, судалгааны хүрээлэн
НЭЭТТ	Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХБ АНДБС	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн салбар
ТББ	Төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар хот
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ҮСХ	Үндэстний статистикийн хороо
ҮХАЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ХБОЭЗНББС	Хүрээлэн буй орчин-эдийн засгийн нягтлан бодох бүртгэлийн систем
ХОСБ	Харилцан ойлголцлын санамж бичиг
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл
ХТЭБХ	Хоёрдогч түүхий эд боловсруулагчдын холбоо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв
ЭХЭХ	Эрчим хүчний зохицуулах хороо

АГУУЛГА

Гарчиг	3
Хураангуй.....	4
1. Танилцуулга	5
1.1 Судалгааны зорилго.....	5
1.2 “Ногоон ажлын байр”-ыг тодорхойлох нь ..	5
2. Судалгааны арга зүй	6
2.1 Салбарын танилцуулга бэлтгэх нь	6
2.2 Хүрээлэн буй орчны үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд боловсруулах нь	7
2.3 Зохимжтой ажлын шалгуур үзүүлэлтүүд ..	7
2.4 Ногоон салбар, дэд салбарууд дахь хөдөлмөр эрхлэлтийн тооцоо	8
2.5 Сорилт хийгээд таамаглалууд.....	8
3. Монгол Улсын эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн байдал.....	10
3.1 Танилцуулга	10
3.2 Эдийн засаг дахь хөдөлмөр эрхлэлтийн зонхилох статус.....	10
3.3 Албан бус сектор.....	12
3.4 Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн ..	12
3.5 Дүгнэлт	13
4. Эдийн засаг, аж үйлдвэрийн гол салбарууд дахь ногоон ажлын байр.....	14
4.1 Газар тариалан, мал аж ахуй, ойн аж ахуй	15
4.2 Эрчим хүчний салбар	20
4.3 Ус, хаягдал усны менежмент.....	21
4.4 Хаттуу хог хаягдлын менежмент.....	23
4.5 Тээврийн салбар	24
4.6 Барилга	25
Ашигласан материал.....	27
Хавсралт 1: Тоон мэдээллийн хүснэгтүүд	29

Хураангуй



Энэхүү судалгаагаар Монгол орон дахь ногоон ажлын байрны өнөөгийн нөхцөл байдлын өрөнхий зураглалыг дурсэлсэн болно. Судалгааны үр дүнгээс харахад бидний сонгон авсан зарим салбарыг нийт 569,921 ажлын байр байна¹. Харин үүнээс дөнгөж 11.5%-ийг нь л ногоон ажлын байр гэж үзэж болох юм. Энэ нь Монгол дахь нийт хөдөлмөр өрхлэлтийн 6.2%-ийг эзэлж байна.

1 Тоон мэдээллийн Үндэслэлийн статистикийн хорооноос гаргасан салбарын судалгаанудаас түүвэрлэсэн болно. Мен хорооноос гаргасан 2012 оны Монголын статистикийн билитэд тухайн жилд нийт 506.5 мянган ажлын байр гэж дурдажээ.

Ногоон ажлын байрны талаарх судалгааны үр дүнгийн хураангуйг доорх хүснэгтээс харна уу.

Монгол Улсын эдийн засгийн зарим салбар дахь Ногоон ажлын байр

#	Салбар	Хөдөлмөр эрхлэлт	З ажлын байр	ХБОЭ ажлын байр	Ногоон ажлын байр	%
1	Мал аж ахуй	342,882	42,512	252,915	42,512	12.4
2	Газар тариалан	58,477	20,932	4,591		0
3	Ойн аж ахуй	3,923	3,923	3,923	3,923	100
4	Эрчим хүч	14,500	14,500	1,231	1,231	8.5
5	Ус, шугам сүлжээ, хаягдал ус боловсруулалт	6,538	6,538	5,159	5,159	78.9
6	Хатуу хог хаягдлын менежмент	1,401	300	1,401	300	21.4
7	Тээвэр	72,900	72,900	12,506	12,506	17.1
8	Барилга	69,300	69,300	3,610	0	0
Нийт		569,921	230,905	285,336	65,631	11.5
Хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувь			40.5%	50.0%	11.5%	

З ажлын байр = Зохицойт ажлын байр,
ХБОЭ ажлын байр = Хүрээлэн буй орчинд эзлэй ажлын байр

сайн. Энэ судалгаанд сонгон авсан салбаруудад ажил өрхлэлтийн өсөлт 2012 оны байдлаар хамгийн ондөр байсан юм.

ҮСХ-ноос 2012 онд гаргасан Хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар албан бус секторт 174.5 мянган хүн хөдөлмөр эрхлэж байгаа гэж гарсан нь өмнөх үзүүлэлтээс 26.5%-иар өссөн тоо юм. Гэхдээ 2012 оны байдлаар албан бус сектор дахь цахилгаан, шатахуун; ус, хог хаягдлын менежментийн чиглэлээр ажиллагдын тоо 45.3%-иар буурсан нь ижил төстэй ажлын байрны тоо албан секторт нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж болно.

Ногоон ажлын байрны зураглал судалгааг НҮБ-ын харьяа мэргэжлийн дөрвөн байгууллага, хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж буй Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл хөтөлбөрийн эхний үе шатны нэг хэсэг болгох 2013 оны эцэсээр гүйцэтгэсэн юм. Энэхүү тайланг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс (ЭЗБӨЧСТ), Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санаачилга дэмжлэгийн хүрээнд боловсруулсан. Үүний зэрэгцээ, ЭЗБӨЧСТ-өөс Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийн эхний үе шатны бас нэг хэсэг болох “Монголын ногоон эдийн засгийн төлөөв байдлын судалгаа” хараат бус тайланг гаргасан бөгөөд тус тайлан нь Ногоон ажлын байрны судалгаатай нягт холбоотой юм.

Монгол Улсын эдийн засаг 2008-2012 оны хооронд 31.5%-иар өсчээ. Үүний зэрэгцээ, эрчим хүчиний хэрэглээний алдагдал, бүтээмж багатай хоцрогдсон технологи, дэд бүтцийн хөгжил хангальгүй зарэг нь хүрээлэн буй орчны доройтолд хүргэж байна. Нэмүү өртөг бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ бараг байхгүй учир эдийн засгийн огцом өсөлт нь түүхий эд, тэр дундаа ашигт малтмалын олборлолтоос үүдэлтэй байв.

Сүүлийн үеийн статистик мэдээллээс үзвэл нүүрсхүчлийн хийн ялгаруулалт хамгийн өндөртэй салбар нь эрчим хүчиний салбар байсан бөгөөд мал аж ахуй, ойн аж ахуй, газар ашиглалтын бусад үйл ажиллагаа удаалж байв.

Ногоон ажлын байрны тооцоог гаргахдаа хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, ус/хаягдал усны менежмент, хатуу хог хаягдлын менежмент, барилгын салбарыг сонгож авсан. Учир нь эдгээр салбарууд нийлээд ДНБ-ий 25.7%, улсын хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн 53.4%-ийг бүрдүүлдэг. 2012 оны байдлаар хөдөлмөр эрхлэлтийн 30%-ийг 7.9%-ийн өсөлттэйгээр, ДНБ-ий 14.8%-ийг 21.3%-ийн өсөлттэйгээр дангаараа бүрдүүлж байсан хөдөө аж ахуйн салбар гэхэд ур амьсгалын өөрчлөлтөд өртөх хамгийн өндөр эрсдэлтэй салбар юм.

Ерөнхийдөө нийт хөдөлмөр өрхлэлт тогтвортой-гоор өсч буй бөгөөд хүйсийн тэнцвэр харьцангуй

1. Танилцуулга

Монгол Улс ногоон эдийн засагт шилжих хүсэл эрмэлзэл өндөр байгаагаа илэрхийлэхийн сацуу НҮБ-ын салбар байгууллагуд болох НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр (UNEP), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO), НҮБ-ын Үйлдвэрлэл хөгжлийн байгууллага (UNIDO), НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэн (UNITAR) гэсэн байгууллагуудаас хамтран санаачилсан НЭЗТТ-ийг хэрэгжүүлэх эхний орон болсон билээ.

Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл хөтөлбөр нь Рио+20 бага хурлын тунхаглалын хүрээнд гарсан санаачилга юм. “Бидний хүсч буй ирээдүй” сэдүйн дор 2012 онд зохион байгуулдсан Рио+20 бага хурлын үеэр ногоон эдийн засаг нь тогтвортой хөгжилд хүрч, ядуурлыг бууруулах гол арга зам юм хэмээн тунхагласан. Энэхүү чуулганы тунхаглалаар Нэгдсэн үндэстний байгууллага илүү хүртээмжтэй ногоон эдийн засагт шилжих эрмэлзэл бүхий орнуудад шаардлагатай туслалцаа үзүүлэхийг уриалсан байдаг. НЭЗТТ-ийн хэтийн зорилго нь 2020 он гэхэд 30 оронд хүрээлэн буй орчинд ээлтэй, зохистой ажлын байрыг бий болгож, ядуурлын түвшин бага, иргэдийн сайн сайхан амьдрах орчин дээшилсэн эдийн засаг руу тогтвортой байдлаар шилжихэд дэмжин ажиллахад оршино.

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

НЭЗТТ-ийг хэрэгжүүлэх эхний шатны хүрээнд, өргөн хүрээтэй судалгааны нэгэн хэсэг болгож ОУХБ-аас Монголын эдийн засгийн хөдөлмөр эрхлэлтийг “ногооруулах” нэхцэл, боломжийг судлах ногоон ажлын байрны судалгааг эрхлэн явуулах зорилго тавьсан юм. Энэ судалгаагаар цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны харилцан уялдаа бүхий ерөнхий зураглалыг гаргаж, НЭЗТТ-ийн нөлөөлөл хамгийн өндөр байх салбар, үйл ажиллагааг тодорхойлоход хувь нэмэр оруулахаар зорьсон.

Энэхүү судалгааны зорилго нь ирээдүйд ногоон эдийн засагт шилжих үед ногоон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх салбар, үйл ажиллагааг тодорхойлж ногоон хөдөлмөр эрхлэлтийн нэхцэл, нөөц боломжийг үнэлэхэд оршино. Судалгааны хүрээнд ОУХБ-аас гаргасан зааврын дагуу үндэсний хэмжээнд хүрээлэн буй орчин-эдийн засаг-хөдөлмөр эрхлэлтийн уялдаа холбоог судалж, Монголын хөдөлмөрийн зах зээл дээрх “Ногоон ажлын байр”-ны нэхцэл байдлыг тодорхойлсон. Түүний зэрэгцээ, энэ судалгаагаар Ногоон ажлын байр хөгжүүлэх бололцоотой салбарууд болон Ногоон ажлын байрыг эрчимжүүлэх бодлогын хувилбаруудын талаарх зөвлөмжүүдийг агуулсан болно. Тэдгээр зөвлөмжийг төрийн болон хувийн хэвшилийн оновчтой оролцоо, олон улсын хөгжлийн байгууллагуудын үр дүнтэй туслалцааны талаарх бодлогын зааварчилгаа хэмээн үзэж болох юм.

1.2 “НОГООН АЖЛЫН БАЙР”-ЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

ОУХБ-ын “Хөгжих буй орнууд дахь ногоон ажлын байрны нөөц бололцооны үнэлгээ хийх гарын авлагыг”²-д дурдсаны дагуу “Ногоон ажлын байр” гэсэн нь тухайн салбарын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулж, тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулж буй эдийн засаг дахь шууд хөдөлмөр эрхлэлтийг хэлнэ хэмээн үзэж буй. Үүнд эрчим хүч, түүхий эдийн ашиглалтыг бууруулж, эдийн засгийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нүүрстөрөгчийн хийн ялгарлыг багасгаж, экосистем болон биологийн олон янз байдлыг хадгальж хамгаалахын зэрэгцээ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох буюу хог хаягдал, бохирдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлдэг “зохистой” хөдөлмөр багтах юм. Өөрөөр хэлбэл, одоогийн байдлаар мэдэгдэх буй мэдээлэл өгөгдөл дээр тулгуурлан үзэхэд, ОУХБ-аас гаргасан энэхүү тодорхойлтолтд ажлын зохистой орчинг бүрдүүлсэн, улмаар хүрээлэн буй орчны болон нийгэм, эдийн засгийн нөлөөллөөрөө “ногоон ажлын байр” хэмээн тооцож болох бүх ажлын байрыг хамруулан үзэж болох юм. Харин ногоон ажлын байрны техникийн нарийвчилсан үзүүлэлтүүд орон бүрт харилцан адилгүй байдаг.

2013 оны 10 дугаар сард болсон Олон улсын хөдөлмөрийн статистикчдүүн 19 дүгээр хуралдаанаас гаргасан хүрээлэн буй орчны салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн статистикийн тодорхойлолт нь тус хөдөлмөр эрхлэлтийг улам нарийвчлан авч үзжээ. “Хүрээлэн буй орчин нь хүрээлэн буй орчинтой холбоотой үйл ажиллагааг авч хэрэгжүүлдэг эдийн засгийн бүхий л салбар нэгжүүдээс бүрдэнэ. ХБОЭЗНББС-ийн ерөнхий бүдүүвчид эдгээр үйл ажиллагааг хүрээлэн буй орчинд учирч буй дарамтыг бууруулах буюу арилгах, байгалийн нөөцийн үр дүнтэй хэрэглээг бий болгоход чиглэсэн эдийн засгийн үйл ажиллагааг хэмээн тодорхойлсон байдаг. Эдгээр үйл ажиллагааг хүрээлэн буй орчинтой холбоотой үндсэн хүөр чиглэлд хуваан авч үздэг байна. Үүнд:

- (а) хүрээлэн буй орчныг хамгаалах үйл ажиллагаа
- (б) нөөцийн удирдлагын үйл ажиллагаа.
- а. Хүрээлэн буй орчныг хамгаалах үйл

² Дараах эх үүсвэрээс үзэх боломжтой: http://www.ilo.org/global/publications/books/WCMS_153458/lang--en/index.htm

ажиллагаа гэдэг нь бохирдол болон хүрээлэн буй орчинд учирч болох бусад боломжит доройтлоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах, арилгах үндсэн зорилготой үйл ажиллагааг хэлнэ.

- б. Нөөцийн удирдлагын үйл ажиллагаа гэдэг нь байгалийн нөөцийг хадгалах, тордох, улмаар нөөц барагдахаас урьдчилан сэргийлэх үндсэн зорилго бүхий үйл ажиллагааг хэлнэ.”

ОУХБ АНДБС-аас 2013 онд гаргасан “Ази дахь ногоон ажлын байрны судалгаа (2010-2012)”—ны тайланд шаардлагатай ойлголтууд, судалгааны арга зүйг тодорхойлсон байсан нь ихээхэн тустай байлаа.³ Энэхүү аргазүйг анх Бангладешт туршсан бөгөөд Ази, Номхон далайн таван оронд хэрэгжүүлсэн. Энэхүү судалгаанд хүлэмжийн хийн ялгаруулалт багатай хөгжил, хүрээлэн буй орчны тогтвортой байдал, ур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход хувь нэмэр оруулах боломжтой ногоон ажлын байрны талаар судалдаг юм. Судалгааг үе шаттайгаар хэрэгжүүлэх ба юуны өмнө хүрээлэн буй орчинтой холбоотой үндсэн ажлын байруудыг үнэлж, үүний дотор ОУХБ-аас гаргасан зохистой ажлын байрны тодорхойлолтод нийцэх хэсгийг нь ногоон

ажлын байр гэж үздэг байна. Үүн дээр тулгуурлан, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ), салбарын яамдын холбогдох албан тушаалтнууд, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрлэлийн танхим (МҮХАҮТ), Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (АОЭНХ), Монголын Үйлдвэрчний холбоо (МҮЭХ) зэрэг холбогдох байгууллагууд болон энэхүү салбарт судалгаа хийдэг эрдэмтэд, судлаачидтай зөвлөлдсөний үндсэн дээр хүрээлэн буй орчинтой холбоотой болон зохистой хөдөлмөр эрхлэлтийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан болно.

“Ногоон ажлын байр”-ны цөм хэсгийг дүрслэн үзүүлэхийн тулд дараах графикт хүрээлэн буй орчинтой холбоотой болон зохистой хөдөлмөр эрхлэлтийн огтлолцлыг харуулж байна.



³ Шууд ногоон ажлын байрны шинж чанарыг сонгон авсан салбарууд дахь хүрээлэн буй орчны болон хөдөлмөрийн үзүүлэлтүүд дээр тулгуурлан тодорхойлсон. Энэ хүрээнд, үндэсний хэмжээний үзүүлэлт талт оролцож байсан байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр тодорхой зарим ногоон туршлага, бүтээдэхүүн, үйлчилгээ судалж, хүрээлэн буй орчны болон зохистой хөдөлмөр эрхлэлтийн гол шалгуур үзүүлэлтүүдийг тоогтоосон болно.

Эх сурвалж: ДХБОСХ 2013 “Малайз дахь ногоон ажлын байрны судалгаа: Өмнө хийгдэж байсан судалгаанууд дээр тулгуурласан ерөнхий дүгнэлт”

2. Судалгааны арга зүй

Монгол Улсад өнөөгийн байдлаар оршин байгаа хийгээд “шууд” ногоон ажлын байрны тооцоог гаргахын тулд дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:

Ажил Тодорхойлолт	Үр дүн
1. Монголын эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий бүтцийг судлах	Эдийн засгийн ерөнхий бүтцийг судлах
2. Хүрээлэн буй орчинтой холбоотой “цөм” ажлын байр болон зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах	Санал болгосон салбар тус бүрээр шалгуур үзүүлэлтүүд боловсруулах
3. Шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан хүрээлэн буй орчинтой холбоотой “цөм” ажлын байрны тооцоог гаргах	“Цөм” салбарууд дахь ажлын байрны тооцоог гаргах
4. Зохистой хөдөлмөр эрхлэлтийн шалгуурыг хангах цөм ажлын байрны тооцоог гаргах	Зохистой хөдөлмөр эрхлэлтийн шалгуур үзүүлэлт болон “ногоон ажлын байр”-ны тооцоо
5. Дүгнэлт – Монгол Улс дахь ногоон ажлын байрны нөхцөл байдал	

2.1 САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА БЭЛДЭХ НЬ

Монголын эдийн засгийн ерөнхий бүтэц, нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор бид өмнө нь хийгдэж байсан судалгаа, мэдээллийд болон Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ноос гаргасан 2008-2012 оны тоон мэдээллийг ашиглав.

Төрийн холбогдох албан хаагчид, судлаачид, ТББ-ын төлөөлөл оролцсон уулзалтын үеэр бид санал болгож буй эдийн засгийн салбар тус бүр дэх уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицолт, сөрөг нөлөөг бууруулах, хог хаягдал болон нөөцийн бууралтад нөлөө бүхий тэргүүлэх үйл ажиллагаануудыг

тодорхойлсон бөгөөд салбар тус бүр дэх хүрээлэн буй орчинтой холбоотой ажлын байрны хэмжээ, тархалтыг авч үзсэн.

2.2 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД БОЛОВСРУУЛАХ НЬ

Хүрээлэн буй орчны “цөм” ажлын байр болон зохистой хөдөлмөр эрхлэлтийн шалгур үзүүлэлтүүдийг боловсруулах зорилгоор өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын баримт бичгийг боловжит мэдээлэл, тоон үзүүлэлтийн дагуу судалж үзсэн.

Эдийн засгийн зарим салбарууд дахь хүрээлэн буй орчинтой холбоотой ажлын байрны шалгур үзүүлэлтийг дараах байдлаар боловсруулсан болно:

- Эхний шалгур үзүүлэлт нь дотоодын болон олон улсын хүрээлэн буй орчны хууль тогтоомжид нийцэж буй эсэх болно. Бохирдлын хяналт, технологи зэрэг нь дотоодын хууль тогтоомжтой нийцэхгүй байгаа аливаа үйл ажиллагаа, үйлдвэрлэлийг хүрээлэн буй орчны “цөм” ажлын байр бий болгож байгаа гэж үзэхгүй бөгөөд жагсаалтаас хасах юм;
- Дараагийн шалгур үзүүлэлт нь хүрээлэн буй орчны сайн дурын стандарт болон ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлтэй холбоотой менежментийн системтэй нийцэж буй эсэх болно;
- Гурав дахь шалгур үзүүлэлт нь төрийн болон /буюу төр/ хувийн хэвшлийн хамтран гаргасан хүрээлэн буй орчны стратегийн төлөвлөгөө, зорилтууд бий эсэх юм. Эдгээр нь тухайн улсын хүсэл эрмэлзэл хийгээд цаашид хандах чиглэлийг илэрхийлж байдаг (тухайлбал, нарны эрчим хүчиний хавтанг нэвтрүүлэх төлөвлөгөө, нийтийн тээврийн хэрэгслийн эрчим хүчиний эх үүсвэрийг өөрчлөх төлөвлөгөө зэрэг);
- Дөрөв дэх шалгур буюу төр болон/буюу хувийн хэвшлээс гаргасан бенчмарк үзүүлэлт буюу тухайн үйлдвэрлэл, салбарын хангах ёстой хамгийн наад захиын үзүүлэлт бий эсэх. Энэ тохиолдолд, үндэсний буюу сайн дурын стандарт, дүрэм журам байхгүй үед судалгаа хийгч нь хүрээлэн буй орчны “сайн” үзүүлэлт гэж юу болохыг тодорхойлох юм. Энэ нь өмнөх алхмууд буюу стандартад суурилсан аргын эсрэг алхам болно;
- Тав дахь шалгуурт үйл ажиллагаанд суурилсан хандлагыг баримтлах бөгөөд тодорхой салбар бус харин тусдаа үйл ажиллагаанууд нь нөөц бага ашигладаг, хүрээлэн буй орчинд зэрэг буюу бага нөлөө үзүүлдэг учир хүрээлэн буй орчны “цөм” ажлын байрны ихэнхийг хангаж байна хэмээн үздэг (тухайлбал, зөгий үржүүлэх/ зөгийн бал

үйлдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөтөлбөрүүд г.м).

2.3 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зохистой хөдөлмөр эрхлэлтийн ойлголт нь ногоон ажлын байрны чухал шалгур үзүүлэлт юм. Энэхүү ойлголтыг ОУХБ-ын оролцогч талууд болох засгийн газар, ажил олгогчид болон ажилчид хамтран тодорхойлсон. Зохистой хөдөлмөр эрхлэлтийн ойлголт нь хувь хүний нэр төр, гэр бүлийн тогтвортой байдал, нийгмийн энх тайван, ард түмэнд үйлчилдэг ардчилал, аж ахуйн нэгжийн өсслэлт хөгжил болон өндөр бүтэээмжтэй ажлын байрыг бий болгодог эдийн засгийн хөгжлийн эх үүсвэр бол ажлын байр мөн гэсэн үзэл дээр тулгуурласан байdag.

ОУХБ-ас Зохистой хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлэх замаар эдийн засаг, нийгмийн бодлогод “зохистой хөдөлмөр эрхлэлт” –д чиглэсэн үзлийг төлөвшүүлэхээр ажилладаг. Зохистой хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр нь дараах дөрвөн тулгуур чиглэлтэй:

- **Ажлын байр бий болго** – хөрөнгө оруулалт, аж үйлдвэр эрхлэх, ур чадвараа хөгжүүлэх, ажлын байр бий болгох, тогтвортой амьжираагаар хангагдах боловжийг бий болгодог эдийн засаг.
- **Ажлын байран дахь эрхийг хангах** – ажилчдын эрхийг хүндэтгэн үзэх, хүлээн зөвшөөрүүлэх. Бүх ажилчид, нэн ялангуяа эмзэг бүлгийн болон ядуу ажилчдад төлөөлөл, оролцоо, тэдний эрх ашигт үйлчилдэг хууль тогтоомж байх нь чухал.
- **Нийгмийн хамгааллыг өргөжүүлэх** – эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн аюулгүй ажиллах орчноор хангагдах, ажил амралтын цагийн тохиромжтой харьцааг баримтлах, гэр бүл, нийгмийн үнэт зүйлсийг харгалзан үзэх, орлогын эх, үүсвэр буурсан буюу алдсан үед зохистой нэхэн олговор авах, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг хангах замаар хүртээмжит байдал болон бүтээмжийг нэмэгдүүлэх.
- **Нийгмийн хэлэлцүүлгийг дэмжих** – Нөлөө бүхий бие даасан ажилчид, ажил олгогчдын төлөөллийн байгууллагуудын оролцог хангах нь бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байран дахь зөрчлөөс зайлсхийх, харилцан ойлголцсон, эвтэй нийгмийг бий болгоход чухал үүрэгтэй.
- Энэхүү тодорхойлолтын дагуу, МҮЭХ, МАОЭНХ, болон төрийн холбогдох байгууллагуудын төлөөлөлтэй зөвлөлдсөний үндсэн дээр Монгол Улс дахь зохистой хөдөлмөр эрхлэлтийн шалгур үзүүлэлтүүдийг дараах байдлаар томьёолсон:
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоосон дүрэм, журамтай,

- Эвлэлдэн нэгдэх, хамтын үзэл бодлоо илэрхийлэх, хэлэлцэн тохиролцох эрхтэй байх,
- Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах,
- Хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэхийг хориглосон,
- Хүүхдийн хөдөлмөр байхгүй буюу хориглосон байх,
- Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт байхгүй.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг дараах хүснэгтэд хураангуйлан үзүүлэв:

Хүснэгт 2.1 Шалгуур үзүүлэлтүүд

Хүрээлэн буй орчны шалгуур	Зохистой хөдөлмөр эрхлэлтийн шалгуур
Хүрээлэн буй орчинтой холбоотой дотоодын хууль тогтоомжид нийцсэн	Хөдөлмөрийн хөлслний доод хэмжээний шаардлагад нийцсэн
Ногоон эдийн засгийн үндэсний хөтөлбөртэй нийцсэн	Эвлэлдэн нэгдэх, хамтын үзэл бодлоо илэрхийлэх, хэлэлцэн тохиролцох эрхтэй
Үйлдвэрлэлийн, салбарын бенчмарк үзүүлэлтүүд болон сайн туршлагатай нийцсэн	Хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэхийг хориглосон, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт байхгүй
Хүрээлэн буй орчинд зөрөг нөлөө бүхий үйл ажиллагаанд сууринсан санаачилгүүд	Хүүхдийн хөдөлмөр байхгүй, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартыг хангасан

Эх сурвалж: ДХБОСХ 2013 “Малайз дахь ногоон ажлын байрны судалгаа: Өмнө хийгдэж байсан судалгаанууд дээр тулгуурласан өрөнхий дүгнэлт”

МҮЭХ эдийн засгийн голлох салбарууд болон газар зүйн бус нутгуудад салбартай. Гишүүдээс дурдвал:

1. Авто замчдын үйлдвэрчний эвлэлийн холбоо
2. Үйлдвэрлэл үйлдвэрчний эвлэлийн холбоо
3. Барилгачдын үйлдвэрчний эвлэлийн холбоо
4. Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо
5. Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны үйлдвэрчний эвлэлийн холбоо
6. Хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын ажилчдын үйлдвэрчний эвлэлийн холбоо
7. Төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбоо
8. Тээвэр, холбоо, газрын тосны үйлдвэрчний эвлэлийн холбоо
9. Эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо
10. Эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо

11. Ажилтан албан хаагчдын үйлдвэрчний эвлэлийн холбоо
12. Нэгдмэл үйлдвэрчний эвлэлийн холбоо
13. Хот байгуулалт, нийтийн аж ахуйн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо

Дээр нэр дурдсан салбаруудын хувьд эвлэлдэн нэгдэх, хамтын үзэл бодлоо илэрхийлэх, хэлэлцэн тохиролцох эрх хангагдсан гэж үзэж болох юм. Гэхдээ гишүүн үйлдвэрчний эвлэлийн холбоод хэлэлцэр хийх чадавхи бэхжүүлэх шаардлага өндер байна.

2.4 НОГООН САЛБАР, ДЭД САЛБАРУУД ДАХЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТООЦОО

Энэхүү тайланд ногоон ажлын байрыг тоон үзүүлэлтээр гаргахын тулд дараах хоёр хандлагад тулгуурласан аргыг хэрэглэсэн болно. Үүнд:

- Бүтээгдэхүүнд сууринсан хандлага буюу батламжлагдсан ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэдэг байгууллагуудыг олж тогтоон, тэдний бий болгож буй ажлын байрыг тоолох. Ажиллах хүчийг тооцоход хэд хэдэн арга ашиглаж болно.
- Явцад сууринсан хандлага буюу тухайн салбар нь хүрээлэн буй орчинд ээлтэй эсэхээс үл хамааран хүрээлэн буй орчинд ээлтэй үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, явцыг олж тогтоон, тэдгээртэй холбоотой ажлын байрыг тооцох.

Энэхүү судалгааны ажлын хугацаа, нөөц боломжид тулгуурлан хүрээлэн буй орчинтой холбоотой салбаруудын талаар нэмэлт мэдээлэл авах үүднээс нэг бүрчлэн дэлгэрэнгүй ярилцлагууд хийгээгүй болно. Харин бодлогын баримт бичиг, өмнө хийгдсэн судалгаа, тоон мэдээлэл зэргийг ашигласан.

2.5 СОРИЛТ ХИЙГЭЭД ТААМАГЛАЛУУД

Хэдийгээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас ногоон ажлын байрыг дэмжсэн зарим бодлогыг хэрэгжүүлж эхлээд байгаа ч Монгол дахь ногоон ажлын байрны төлөв байдлын талаарх хангалттай мэдээлэл байхгүй. Одоо байгаа мэдээлэл үзүүлэлтүүд нь цогц мэдээлэл авахад хангалтгүй бөгөөд тухайн салбар буюу дэд салбарын хүрээнд ашиглахад тохиромжгүй байв. Тоон мэдээлэл дээр ажиллахад дараах гол хүндрэлүүд тохиолдож байлаа. Үүнд:

Ажлын байрны бодит тооцоо байхгүй: Ихэнх тохиолдолд тухайн салбар/дэд салбар дахь ажлын байрны талаар хангалттай мэдээлэл байхгүй байв. Түүнчлэн, тухайн салбар/дэд салбарын хүрээнд ногоон ажлын байр бий болгох боломжтой үйл ажиллагааны талаар тооцоо судалгаа байхгүй байсан.

		Үзүүлэлтүүд	
	Салбар	Үйл явц	Бүтээгдэхүүн
1	Хөдөө аж ахуй		
1.1	Мал аж ахуй	Бэлчээрийн зохистой мэнежментийг нэвтрүүлж буй аливаа үйл ажиллагаа;	<ul style="list-style-type: none"> Мал сургийн тоо толгойг бууруулах Нэгж толгой малын үр өгөөжийг нэмэгдүүлэх Эрчимжүүлсэн фермерийн үйл ажиллагааг нэвтрүүлэх
		Бэлчээрийн чанар, мал сургийн эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээ	Малчид болон малын эмч нарын хамтын ажиллагаа.
		Экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа	Зөгийн аж ахуй
1.2	Газар тариалан	Хөрсний үржилт чанарыг сайжруулж, цөлжилтийг сааруулахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Мод, ургамал тарих, зүлэгжүүлэх Хүлэмж ажиллуулах
2	Эрчим хүч	Эрчим хүчиний салбар дах нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах аливаа үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Сэргээгдэх эрчим хүч Эрчим хүчиний салбарт нүүрс, байгалийн хий ашиглах шинэ технологи
3	Ус, хаягдал усны менежмент	Тухайн орны усны нөөцийг хадгалж үлдэхэл чиглэсэн аливаа үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Ус дахин ашиглалт Ус цэвэршүүлэх
4	Хог хаягдлын мэнежмент	Хатуу хог хаягдлын хэмжээ, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн аливаа арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> Хог боловсруулах Хог хаягдлыг ангилах
5	Тээвэр	Тээврийн салбар дахь нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн аливаа арга хэмжээ	Хүрээлэн буй орчинд ээлтэй нийтийн тээврийг нэвтрүүлэх Засгийн газрын дунд хугацааны хөтөлбөртэй нийцэх аливаа үйл ажиллагаа
6	Барилга	Хөрсний доройтлыг бууруулахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Авто зам тавих Усны шугам, хоолой байгуулах Гүүр барих

Өгөгдлүүд нарийвчлан ангилагдаагүй: Ажлын байрны талаарх мэдээллийг ихэвчлэн хэт өргөн хүрээнд нэгтгэсэн байв. Тухайлбал, тээврийн салбар дахь ажлын байрны тооцоог агуулах, хадгалалттай нэгтгэсэн байх Г.М.

Бодитоор хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээлэл хомс: Ур амьсгалын өөрчлөлтөд чиглэсэн Засгийн газрын бодлогын санаачилга болон стратеги, санхүүжилт зэргийн талаар мэдээлэл харьцангуй их боловч амьдрал дээр ямар төсөл хэрэгжсэн, улмаар тэдгээр төслийн үр дүнд бий болсон ногоон ажлын байрны талаар мэдээлэл маш хомс байв.

“Богино хугацааны ногоон төслүүд”-ийн дүнд бий болох ногоон ажлын байрны тоог хэрхэн тооцож: Жишээлбэл, тодорхой нэгэн газарт мөд тарих зэрэг хүрээлэн буй орчны бие даасан эсвэл богино-хугацааны төслүүд хэрэгжсэнээр түр ажлын байр бий болгож байдаг. Гэсэн хэдий ч эдгээр ажлын байрны талаар мэдээлэл байдаггүй.

Тоон өгөгдлийн нийцэл: Үндэсний статистикийн хорооноос авсан өгөгдлүүд болон тухайн салбарын байгууллагуудаас авсан өгөгдөл ихэвчлэн ялгаатай байдаг. Тиймээс нийт судалгаанд ҮСХ-ны тоон өгөгдлийг ашигласан болно.

3. Монгол Улсын эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн байдал


Монголын эдийн засгийн өнөөгийн байдал, сүүлийн үеийн чиг хандлагыг ДНБ-ий өсөлттөөр илэрхийлж болох бол хүн ам зүйн өнөөгийн байдлыг хөдөлмөр эрхлэлтээр харуулж болох юм. Харин хөдөлмөрийн зах зээлд энэ хоёр үзүүлэлтийн аль алины үзүүлэл нэлөө их.

3.1 ТАНИЛЦУУЛГА



Монголын эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2008-2012 онд 8.7% байсан. Жил тутмын харьцуулалтаар, 2013 оны 9 дугаар сарын байдлаар бодит ДНБ 11.5%-ийн өсөлттэй байсан нь 2012 оны өсөлттэй харьцуулахад 0.8%-р бага байв.

График 3.1: Эдийн засаг өсч, ядуурал буурав



Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2012; YCX

Эдийн засгийн өсөлтийн энэ үед нэг хүнд ноогдох ДНБ 3,600 ам.долларт хүрсэн нь 2009 онтой харьцуулахад 1.1 дахин өсч, ядуурлын түвшин мөн оныхтой харьцуулахад 11.3%-иар буурч 27.4%-д хүрчээ. Харин сүүлийн 3 жилийн турш ядуурал жилд дунджаар 5-5.3%-иар буурч байв.

Хүснэгт 3.1-т үзүүлсэнчлэн Монгол Улсын хувьд хамгийн чухал ач холбогдолтой салбарууд нь хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, барилга, тээвэр, үйлчилгээний салбар юм. Эдийн засгийн гол салбаруудыг 2012 оны байдлаар ДНБ-д оруулах хувь нэмэрээр нь жагсаавал уул уурхай (21.4%), хөдөө аж ахуй (14.8%), боловсруулах үйлдвэр (8.0%), тээвэр (6.6%), санхүү болон даатгал (3.6%), харилцаа холбоо (3.1%) байв (Хавсралт дахь Хүснэгт 1-ийг үз).

Харин дээрх салбаруудыг өсөлтийн хувиар нь ангилбал хамгийн хурдан буюу 25.6%-ийн өсөлттэй барилга, 25.7%-ийн өсөлттэй санхүү, даатгалын салбар тэргүүлж байсан бөгөөд хөдөө аж ахуй (21.3%), тээвэр (12.8%), уул уурхайн салбар (8.9%)-үүд удаалж байв.

Эдийн засгийн өсөлт хөдөлмөр эрхлэлтэд мөн эзргээр нөлөөлсөн. Ажилгүйдлийн түвшин 2013 оны 10 дугаар сарын байдлаар 7.3%-д хүрсэн нь өмнөх жилтэй харьцуулахад 1.7%-иар буурсан үзүүлэлт юм. Нэгөө талаас, валютын ханшны савлагаа хөдөлмөр эрхлэлтэд сөрөг нөлөө үзүүлсэн. 2013 оны эхний 10

сард л гэхэд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 30%-иар унажээ.

Түүнчлэн, 2011 онтой харьцуулахад гадаад худалдааны тэнцэл 2012 онд 2.6% буюу 292.9 ам.доллараар өсч 11,123.0 сая ам.долларт хүрсэн ба үүнээс экспорт 4,384.7 сая ам.доллар, импорт 6,738.3 сая ам.долларыг эзэлж байв. Экспорт 9.0%-иар буурсан бол импорт 2.1%-иар өсчээ.

Монголын экспортын ихэнх хэсгийг ашигт малтмал эзэлдэг. Нийт экспортын 83.2% орчим нь боловсруулаагүй түүхий эд, 15.1% нь анхан шатны боловсруулалт хийгдсэн, 0.8% нь дунд түвшний технологиор боловсруулалт хийгдсэн, дөнгөж 0.02% нь өндөр түвшний технологиор боловсруулалт хийгдсэн байдаг байна.⁴

График 3.2 Ажилгүйдэл ба инфляци



Эх сурвалж: Сарын статистикийн бюллетень, 2013 оны 11 дугаар сар, YCX; www.nso.mn

3.2 ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗОНХИЛОХ СТАТУС



Монгол Улсын хүн ам 2012 онд 2,867.7 мянга байсан ба жилийн дундаж өсөлт нь 1.9% байв. Үүнээс 48.6% нь эрэгтэй, 51.4% нь эмэгтэй; мөн 45.9% нь нийслэл Улаанбаатарт, 21.3% нь бусад хот суурин газарт, 32.8% нь хөдөө орон нутагт амьдарч байв. Нэг өрхөд ойролцоогоор 3.7 хүн ноогдохын зэрэгцээ 1 кв.км-т 2 хүн ноогдох байв. Дундаж наслалт 68.7 болсон нь 2006 онтой харьцуулахад бараг 2.9 жилээр нэмэгдсэн байв.

Монгол дахь бичиг үсэгт тайлгадагсдын тоо өндөр. Арав буюу түүнээс дээш насны хүн амын 97.8% орчим нь бичиг үсэгт тайлгадсан ба сургуулийн насны хүхжүүдийн 80.7% нь сургуульд хамрагддаг.


⁴ Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2012; YCX

Энэ хоёр үзүүлэлтэд тулгуурлаж тооцож гаргадаг боловсролын индекс 0.91⁵-тай тэнцэж байна.

Боловсролын түвшний тухайд, арав буюу түүнээс дээш насын хүн амын 19.8% нь дээд боловсрол, 6.2% нь тусгай мэргэжлийн боловсрол, 3% нь техникийн мэргэжлийн боловсрол, 34.6% нь бүрэн дунд, 19.3% нь дунд боловсрол, дөнгөж 17% нь бага боловсрол эзэмшсэн байна. Дээд боловсролын түвшин эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдийнхээс хурдтай ёсч байна. 2000 болон 2010 онд тус тус хийсэн хүн амын тооллогын хооронд дээд боловсролтой эрэгтэйчүүдийн тоо хоёр дахин ёссэн бол дээд боловсролтой эмэгтэйчүүдийн тоо 2.8 дахин ёсчээ⁶.

Монголын хүн амын насжилт хурдаасч байна. Тухайлбал, 2010 онд 14-өөс доош насын хүн ам 27.3%, 14-64 насын хүн ам 68.9%, 65-аас дээш насын хүн 3.7% байсан. Харин 2030 он гэхэд энэ харьцаа 23.8%, 68.3% болон 7.9% болж өөрчлөгдөх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, 65-аас дээш насын хүн амын тоо хоёр дахин нэмэгдэнэ гэсэн уг. Гэсэн хэдий ч Монгол Улсын хөгшин хүн амтай улс болоход хол байна.

График 3.3 Хүн амын хувь насын бүлгээр, 2010-2030, мянган хүн



Эх сурвалж: "Хүн амын байршил, суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа" Үндэсний хөгжлийн хүрээлэн, хуудас 18, 2012; Хүн ам, орон байрны судалгаа 2010, YCH

2012 онд нийт хүн амын 63.2%-ийг хөдөлмөрийн насын хүн эзэлж байсан нь 2009 онтой харьцуулахад 5%-иар буурсан байв. Судлаачдын таамаглаж буйгаар нийт хүн амд эзлэх хөдөлмөрийн насын хүмүүсийн хувь хэмжээ 2030 оныг хүртэл өнөөгийн түвшнээс буурахгүй бөгөөд 2025-2030 онд хүн амын цонх дахин тохиосноор хөдөлмөрийн насын хүн амын тоо хамгийн дээд түвшиндээ хүрэх аж⁷ (График3.3-ыг үз).

Мөн 2009-2012 оны хооронд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн оролцоо буурсан бол (66.8%-иас

⁵ Д.Ганбат, Отгонтэнээр их сургуулийн багш, 2013: Япон Улстай байгуулсан чөлөөт худалдааны хэлцлийн нийгэм, эдийн засгийн үр дагавар, хуудас 23

⁶ Монгол Улсын статистикийн эмхэтгээл 2012; YCH

⁷ Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2012: "Хүн амын байрлал, суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа", хуудас 7

63.5% болж) эрэгтэйчүүдийн хувьд ёсчээ. Харин нөгөө талаас, хөдөлмөр эрхлэлт мөн адил хувиар тогтвортой ёссэн (88.4%-иас 91.8% хүрч) бөгөөд хөдөлмөр эрхлэгчдийн хүйсийн тэнцвэр харьцангуй сайн (91.6%/91.9%) байна. Хөдөө аж ахуйгаас бусад салбарын хувьд тогтмол цалинтайгаар хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс бага зэрэг доогур (47.4% – 47.8%) байна (Хавсралт дахь Хүснэгт 2-ыг үз).

Албан болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдыг оруулаад нийт хөдөлмөр эрхлэгчдийн 35% орчим нь хөдөө аж ахуйн салбарт, 25.7% нь үйлчилгээний салбарт, 17.7% нь териийн байгууллагад, 13.8% нь аж үйлдвэрлэлийн салбарт, 4.4% нь уул уурхайн салбарт ажиллаж байна. Үлдсэн 3.4% нь өөр салбаруудад ажиллаж байна (Хавсралт дахь Хүснэгт 3-ыг үзэх).

2012 оны байдлаар нийт хөдөлмөр эрхлэгчдийн 47.5% нь цалинтай, 30.2% нь малчид, 16.9% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 4.3% нь өрхийн үйлдвэрлэлд цалингүйгээр оролцогч байв. Мөн 0.9% нь ажил олгогчид байсан бөгөөд 0.2% нь эдгээр ангиллын алинд ч багтахгүй байжээ.⁸

Монгол Улсын Засгийн газраас (МУЗГ) 2011 оныг "Хөдөлмөр эрхэлэтийг дэмжих жил" болгон зарлаж, ажлын байр болгоход чиглэсэн хэд хэдэн бодлого хэрэгжүүлсэн. Үүний дунд 2011-2013 оны хооронд жилд дунджаар 62.1 мянган ажлын байр шинээр бий болж, ажилгүйдлийн түвшин буурчээ.

2013 оны 10 дугаар сарын байдлаар бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 0.6% нь магистр, докторын зэрэгтэй, 29.3% нь бакалаврын болон бусад дипломтой, 6.9% нь тусгай мэргэжлийн боловсролтой, 6.5% нь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг дүүргэсэн, 41.8% нь бүрэн дунд, 10.9% нь бүрэн бус дунд, 3.1% нь бага боловсролтой байсан ба 0.9% нь албан боловсрол эзэмшээгүй байжээ.

Дээд боловсролтой хүмүүс нийт бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 1/3-ийг эзэлж байна гэдэг нь хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг харуулж байна. Хөдөлмөр эрхлэлт хамгийн эрчимтэйгээр есч буй салбаруудад усны нөөц, усны шугам сүлжээ, хог хаягдлын мөнөжмент болон нөхөн сэргээлт (30.5%), харилцаа холбоо (27.5%); эрчим хүчиний үйлдвэрлэл, байгалийн хий (21.5%), барилгын салбар (13.9%) тус тус орж байна. Түүнчлэн, хөдөө аж ахуй, үйлчилгээ, барилга, тээвэр, агуулах, уул уурхай зэрэг ажиллах хүчиний эрэлт хамгийн өндөр байдаг салбаруудад заавал дээд боловсролтой бус харин ихэвчлэн мэргэжлийн сургалтын төвийн сургалгад хамрагдсан ажилчид шаардлагатай байдаг.

⁸ YCH-ны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны хамтарсан тушаалаар батлаадсан "Хөдөлмөр эрхэлэлт, ажиллах хүчиний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-д дурдагдсан тодорхойлолт

3.3 АЛБАН БУС СЕКТОР

Монголын хүн амын хувьд албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлт нь орлогын томоохон эх үүсвэр мөн. МУЗГ-аас албан бус хөдөлмөр эрхлэлтийг “албан ёсны бүртгэл, мэдээлэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, хөдөө аж ахуйн бус, аж ахуй эрхлэх аливаа нэгэн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээг хувь хүн, ерх, хамтлаг эрхлэхийг хамруулна” гэж тодорхойлжээ.⁹

МУЗГ-ын энэхүү тодорхойлолт нь хөгжиж буй орнуудын хөдөө аж ахуйн салбар дахь албан болон албан бус үйл ажиллагааг тодорхойлоход бэрхшээлтэй байдгийн улмаас тус салбарыг албан бус хөдөлмөр эрхлэлтээс хасах шийдвэр гаргасантай нийцэж байна.¹⁰ Тийм ч учир хөдөө аж ахуйгаас бусад бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх үйл ажиллагаанд газар тариалан, ойн аж ахуй, мал аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт, хөдөө ахуйн машин техникийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээ, ашиглалт, агуулах, тээвэр зэргээс бусад бүх үйл ажиллагааг хамруулж үзэх юм.

ҮСХ-ны 2012 оны хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар 174.5 мянга орчим хүн албан бус секторт ажиллаж байсан бөгөөд үүний 56.3% нь эрэгтэй, 43.7% нь эмэгтэй байв. Албан бус сектор дахь хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг анхдагч буюу дам хөдөлмөр эрхлэлт хэмээн ангилж болох бөгөөд үүний 94.5% орчим нь албан бус секторт анхдагч хөдөлмөр эрхэлдэг байна.

Өмнөх жилтэй харьцуулахад албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн тоо 26.5%-иар өсчээ. Тэр дундаа, албан бус салбарт дам хөдөлмөр эрхлэгч эрэгтэйчүүдийн тоо бараг хоёр дахин нэмэгдсэн байна (Хавсралт дахь Хүснэгт 4-ийг үз).

Хүн амын тархалт суурьшлын үүднээс авч үзвэл хот суурин газрууд, тухайлбал УБ-т хүн амын 71.7% нь албан бус секторт ажилладаг бол хөдөө орон нутагт энэ хувь дөнгөх 28.3% байна. Бус нутгаар авч үзвэл, УБ-т 43.9%, Хангайн бүсэд 20.4%, Баруун бүсэд 16.8%, Төвийн бүсэд 14.9%, Зүүн бүсэд 4.0% байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны төрлөөр үзвэл албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийн ихэнх нь бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг (44.4%) бөгөөд тээвэр, агуулахын үйлчилгээ (17.2%), аж үйлдвэрлэл (15.7%), барилга (5.8%), уул уурхайн салбар (3.5%) удаалж байна. Харилцаа холбоо, боловсрол, эрүүл мэнд, цахилгаан эрчим хүч, ус, хаягдал усны менежмент, санхүү даатгал,

зочид буудал, нийтийн хоолны сүлжээ, соёл урлаг зэрэг бусад салбар 13.4%-ийг эзэлж байна. 2011 онтой харьцуулахад эрэгтэй хөдөлмөр эрхлэгчдийн өсөлт эмэгтэйчүүдийнхээс доогуур; өөрөөр хэлбэл албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлтийн гол хэлбэр нь эмэгтэйчүүд эрхлэхэд харьцангуй дөхөм жижиглэнгийн болон гудамжны худалдаа байдаг учир илүү олон эмэгтэйчүүд албан бус секторт орж байна (Хавсралт дахь Хүснэгт 5-ыг үзэх).

Салбарын хувьд хамгийн том өөрчлөлт нь худалдаа эрхлэгчдийн тооны өсөлт байсан бөгөөд эсрэгээр машинтехникийн оператор, үйлдвэрлэл, гар урлал болон бусад холбогдох чиглэлээр ажиллагсад, туслах ажилтан зэрэг жижиг хэмжээний үйлдвэрт ажиллагсдын тоо бууручээ. Түүнчлэн, цахилгаан эрчим хүч, ус, хаягдал усны менежментийн чиглэлээр ажиллагсдын хувь хэмжээ мөн буурсан байна. Албан бус секторт эдгээр чиглэлээр ажиллагсдын тоо 2012 онд буурсан шалтгааныг албан секторт ижил төстэй ажлын байр нэмэгдсэнтэй холбоотой хэмээн үзэх болно (Хавсралт дахь Хүснэгт 6-ыг үзэх).

3.4 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Монголд цалингийн хэмжээ доогуур байдгаас олон тооны монголчууд хилийн чанадад ажиллаж байна. Гадаадад ажиллагч монголчуудын тоо нийт ажиллах хүчиний 11% орчимд хүрчээ.

Ойролцоогоор 120,000 орчим монголчуд хилийн чанадад ажиллаж байгаагаас дийлэнх нь Өмнөд Солонгост (40,000 хүн), АНУ (28,000 хүн), Англи (9,000 хүн), Чех (5,800 хүн), Японд (5,600) ажиллаж байна¹¹. Хилийн чанадад ажиллагсад шинэ технологи, ойлголтыг эх орондоо авчрах замаар хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулдаг. Түүнчлэн тэд гадаадаас валютын гүйвуулга хийх замаар Монголын ДНБ-ий өсвөлдэд зохих нөлөө үзүүлдэг байна. Мөн зарим тохиолдолд тэд эх орондоо ноухау, шинэ технологи нэвтрүүлдэг. МУЗГ-аас гадаадад ажиллаж амьдарч буй монголчуудыг эргүүлэн татах, эх орондоо эргэн ирэхэд нь туслалцаа үзүүлэх зорилготой “Зөгийн үүр” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч өнөөгийн байдлаар тус хөтөлбөрийн үр дүн тийм ч сайн биш байна.

Монголчууд бусад улс руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс гадна дотооддоо хөдөөгөөс хот руу чиглэсэн болон салбар хоорондын ажиллах хүчиний шилжилт хөдөлгөөн их байна.

⁹ Монгол Улсын Их Хурлын “Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого” батлах тухай тогтолцооны Хавсралт 1-ийн 1.3 дахь заалт

¹⁰ 2012 оны хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, хуудас 62. ҮСХ 2013: www.nso.mn

¹¹ Д.Ганбат, Отгонтэнээр их сургуулийн багш, 2013: Япон Улстай байгуулсан чөлөөт худалдааны хэлцлийн нийгэм, эдийн засгийн үр дагавар, хуудас 25

3.5 ДҮГНЭЛТ



Монгол Улсын эдийн засаг 2008 оноос эхлэн тогтвортой ёсч, жилд дунджаар 8.9%-иар ёсч байна. Нэг хүнд ноогох ДНБ 3,600 ам.долларт хүрснээр Монгол Улс доогуур-дундаж орлоготой орны эгнээнд шилжлээ.¹² Эдийн засгийн эерэг үзүүлэлтээс үүдэн ядуурлын түвшин (27.4%) болон ажилгүйдэл (7.3%) буурсан байна.

2012 оны статистик үзүүлэлтээс үзвэл уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, тээврийн салбар ДНБ-д томоохон хувь нэмэр оруулсан хэдий ч хамгийн хурдацтай ёсч буй салбарууд нь барилга, санхүүгийн зуучлал, хөдөө аж ахуй байв.

Монголын экспортод ашигт малтмал зонхицдог бөгөөд дотооддоо нэмүү өртөг бүтээх үйл ажиллагаа байхгүйтэй ижил. Түүхий эд боловсруулах үйлдвэрийн тоог нэмэгдүүлэх нь ажлын байр бий болгож, улмаар ядуурлыг бууруулахад зохих нөлөө үзүүлнэ.

Монгол Улсын хүн ам харьцангуй хурдацтай буюу жилд 2% орчмын өсөлттэй байна. Гэсэн хэдий ч хүн амын насхилт эрчимтэй явагдаж буй бөгөөд хөдөлмөрийн насны хүн амын хувь 2030 он хүртэл өнөөгийн түвшнээсээ буурахгүй бөгөөд 2025-2030 онд хамгийн дээд түвшиндээ хүрэх юм. Бичиг үсэг

тайлагдалт өндөр бөгөөд боловсролын индекс 0.91 байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй байгаа шинэ ур чадвар сурахад эерэгээр нөлөөлөх хүчин зүйл юм.

Хөдөлмөр эрхлэлт тогтвортой ёсч байгаа (88.4%-ас 91.8% хүрсэн) бөгөөд хүйсийн тэнцвэр харьцангуй сайн (91.6%/91.9%). Монголд нийт 1,056.4 мянган хүн хөдөлмөр эрхэлж байгаагаас 506.5 мянга нь энэ судалгаанд хамрагдсан салбаруудад ажиллаж байна.

Энэ судалгаанд хамрагдсан салбарууд 2012 онд хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр байв. Тухайлбал, усны нөөц, шугам сүлжээ, хог хаягдлын менежмент, нөхөн сэргээлтийн чиглэлээр хөдөлмөр эрхлэлт 30.5%-иар, эрчим хүч болон байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр эрхлэлт 21.5%-иар, барилга 13.9%-иар, хөдөө аж ахуйн 7.9%-иар өссөэ.

УСХ-ны 2012 оны Хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар 174.5 мянга орчим хүн албан бус секторт ажилладаг гэж гарсан нь 26.5%-иар өссөн үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч цахилгаан эрчим хүч, ус, хаягдал усны менежментийн чиглэлээр ажиллагдсын хувь хэмжээ 45.3%-иар буурсан байна. Албан бус секторт эдгээр чиглэлээр ажиллагдсын тоо 2012 онд буурсан шалтгааныг албан секторт ижил төстэй ажлын байр нэмэгдсэнтэй холбоотой хэмээн үзэж болно.

¹² Дэлхийн банк. Улсуудын ангилал <http://data.worldbank.org/about/country-classifications>



4. Эдийн засаг, үйлдвэрлэлийн гол салбарууд дахь ногоон ажлын байр

Эдийн засгийн өсөлт нь хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж, байгалийн нөөцийн доройтолд хүргэдэг гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөх болжээ.¹³ Сүүлийн 25 жилийн хугацаанд дэлхийн эдийн засаг 4 дахин өссөн хэдий ч үүний нөгөө талд байгалийн нөөцийн зохисгүй ашиглалтын улмаас дэлхийн экосистемийн 60% орчим нь тогтвортгүй болсон. Энэ үзүүгээ Монголын хувьд ч мөн хамаатай. Хэдийгээр Монголын эдийн засаг 2008-2012 оны хооронд 31.5%-ар өссөн ч хүрээлэн буй орчин, экосистемийн нөхөн сэргээлтэд маш бага хувь нь зарцуулагджээ.

Дэлхийн дундажтай харьцуулахад 1 ам.доллар ДНБ үйлдвэрлэхэд Монгол долоо дахин их эрчим хүч зарцуулдаг (0.39 кг нэгж түлш/ам.доллар ба 3.04 кг түлш/ам.доллар). Хэдийгээр нэг хүнд ноогдох нүүрстөрөгчийнхийн ялгаруулалтаар дэлхийн дунджаас бага хэдий ч, нүүрстөрөгчийнхийн ялгаруулалтыг ДНБ-тэй харьцуулвал Монгол дэлхийн дунджаас 10 дахин өндөр (0.75 кг/ам.доллар ба 7.5 кг/ам.доллар) байна¹⁴. 1940-2008 оныг хамарсан судалгаагаар Монголын агаарын дундаж температур 2.14 хэмэр нэмэгдсэн гэж гарсан нь дэлхийн дунджаас даруй 3 дахин өндөр байгаа юм.

13 <http://data.worldbank.org/about/world-development-indicators-data/environment>

14 Монгол Улсын статистикийн эмхэтээл 2012; YCSX

Түүнчлэн, 2006 оны статистикаас үзвэл нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтын 64.4%-ийг эрчим хүчний салбар, 41.4%-ийг мал аж ахуй, 13.3%-ийг ойн аж ахуйн болон газар ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй гэжээ¹⁵. Иймээс эрчим хүчний салбарыг энэ судалгаанд сонгон авсан юм.

Цаашилбал, 2012 онд нийт хөдөлмөр эрхлэлтийн 30% орчмыг 7.9%-ийн өсөлттэйгээр, ДНБ-ий 14.8%-ийг 21.3%-ийн өсөлттэйгээр дангаараа бүрдүүлж байсан мал аж ахуйн салбар нь уур амьсгалын өөрчлөлтэд хамгийн ихээр өртөх магадлалтай салбар бөгөөд ногоон ажлын байрны судалгаанд мөн хамруулсан болно.

Тээврийн салбарыг Засгийн газар сонгон авч, экологийн хувьд хор хөнөөлгүй нийтийн тээврийн салбарыг хөгжүүлснээр хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах боломжтой хэмээн үзэж буй. Ус, хаягдал усны менежмент нь Монгол шил хуурай орны хувьд усны нийт хэрэглээний хэмжээг бууруулах ач холбогдолтой бөгөөд хатуу хог хаягдын менежментийн нэгэн адил хүрээлэн буй орчныг хамгаалах хувь нэмэр оруулах боломжтой хэмээн мөн судалгаанд багтсан юм.

Сайжруулсан болон засмал зам багатай учир ачааны машинууд дураараа зам гаргах үзэгдэл түгээмэл бөгөөд зарим зам нэг км, эсвэл түүнээс чөргөн байх нь бий. Их хэмжээний хөрсний доройтол үүнээс үүдэлтэй бөгөөд зам тавих, гүүр барих барилгын салбарыг мөн сонгосон.

Сонгож авсан салбарууд нийтдээ ДНБ-ий 25.7%

орчмыг бүрдүүлдэг бөгөөд нийт хөдөлмөр эрхлэлтийн 53.4%-ийг эзлэдэг.

Эдийн засагчид уул уурхайн салбарыг ойрын ирээдүйд Монголын өсөлтийн хангах гол хүч хэмээн үзэж буй. Уул уурхайн салбар 2012 оны сүүлчээр нийт ДНБ-ий 21.4%-ийг бүрдүүлж байсан ба жилийн дундаж өсөлт нь 8.9% байв. Гэсэн хэдий ч хөдөлмөр эрхлэлтийн дөнгөж 4.4%-ийг 3.5%-ийн өсөлттэйгээр бүрдүүлж байсан бөгөөд эрчим хүч, мал аж ахуйн салбаруудтай харьцуулахад нүүрстөрөгчийн хийл ялгаруулалтад тухайлсан нөлөө байхгүй, уур амьсгалын өөрчлөлтэд өртөх эрсдэл багатай учир энэ судалгаанд багтаагаагүй юм.

НҮБХБОХ-өөс ногоон эдийн засгийг “Хүрээлэн буй орчны эрсдэл болон экологийн хомсдлыг эрс бууруулах, хүний сайн сайхан байдал, нийгмийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн байх бөгөөд хамгийн энгийн хэлбэрээр гэвэл ногоон эдийн засаг нь нүүрстөрөгчийн хийн ялгаруулалт бага, нөөцийн хувьд үр ашигтай, нийгмийн хувьд хүртээмжтэй байх юм¹⁶” гэж тодорхойлжээ.

Монгол дахь ногоон ажлын байрыг тодорхойлоход энэ тодорхойлолтыг ашигласан бөгөөд дээр дурдсан салбарууд дахь зохицтой хөдөлмөр эрхлэлтийн шаардлагыг хангаж байгаа бүх ажлын байрыг ногоон ажлын байр хэмээн үзэж байгаа юм.

Ногоон ажлын байрыг тодорхойлоход ашигласан бас нэг чухал баримт бичиг нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны 4 тоот тогтооолоор батлагдсан “Эзэнтэй монгол” хөтөлбөр юм.

15 М.Алтанбагана, Докторын зэрэг горилогч, УХХ-ийн секторын дараа, 2012 оны 8-р сарын 28: Оролцоог урамшуулах замаар малчдын нүүрстөрөгчийн хийг бууруулах тэмцэлд татан оролцуулъя, altanbagana44blog.spot.com/2012/08/blog-post.html#more

16 <http://www.unep.org/greenconomy/aboutgei/whatisgei/tabid/29784/default.aspx>

Тус хөтөлбөрийн гол зорилго нь дараах үйл ажиллагаа явуулагч иргэний бүлэгт дэмжлэг үзүүлэх замаар иргэдийн эх орныхоо эзэн болох, нийгмийн үүрэг хариуцлагын ухамсыг сэргээх, нийгмийн үйл хэрэгт оролцох боломжоор хангахад оршино. Үүнд:

- Нийтийн сайн сайхны төлөөх хөрөнгө оруулалт, ногоон хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах,
- Газрын хамгаалал,
- Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг сахиулан хадгалан, хамгаалах
- Хог хаягдлын зохистой менежментийг нэвтрүүлэх,
- Эрсдлийг сааруулах.

Хөтөлбөрийн танилцуулга нь амьдрах таагүй орчинд хүргэж буй хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн иргэдийн санаачилгыг дэмжих төрийн хүсэл эрмэлзээл гэжээ.

Хөтөлбөрийн дагуу жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд ногоон ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилт бий. Үүнд: эко-бизнес төслийдийг олж тогтоох замаар экологийн хэмнэлттэй хэрэглээ нэвтрүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэрлэлийг олж тогтоох, зөвлөн зээл олгох аргаар санхүүжилт авах боломжоор хангах, сургалт явуулах зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан хүрээлэн буй орчин, ногоон дэлхийд ээлтэй эдийн засгийн үндэс суурийг тавих.

Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас “5x20” зорилт, “Ногоон оффис”, “Органик Монголд үйлдвэрлэв” “Ногоон бүтээгдэхүүн ба шошгожуулалт”, “Ногоон зээл” зэрэг Ногоон хөгжлийг дэмжих хэд хэдэн санаачилга гаргасан¹⁷.

Үүний зэрэгцээ, хувийн хэвшлийн зарим байгууллага ногоон эдийн засгийг ач холбогдлыг ухамсарлаж, ногоон хөгжлийн арга замыг эрэлхийлж байна. MYXAYT-аас гадна Хас, Голомт зэрэг банкууд мөн бизнесийн үр ашигт байдал дээр тулгуурлан ногоон зээл, хөрөнгө оруулалтын стратегийг баримталж, Ньюком Групп зэрэг компаниуд ногоон эрчим хүчиний эх үүсвэрийг байгуулж байна.

Түүнчлэн, Дэлхийн банк, АХБ, ЕСБХБ зэрэг олон улсын байгууллагууд агаарын бохирдол, усны менежмент зэрэг хүрээлэн буй орчны асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төслийд санхүүжилт олгохын сацуу сэргээгдэх эрчим хүчиний дэд бүтэц бий болгоход зориулж зээл олгож байна. Олон улсын ногоон ёсөлтийн санаачилга, Дэлхийн байгаль хамгаалах сан зэрэг ТББ-үүд хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр тус тусын төслүүдээ хэрэгжүүлж, байна.

¹⁷ Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, MYXAYT-ын талаар дэлгэрэнгүй мэдээллийг ЭЗБӨЧСТ-ийн ‘Ногоон эдийн засгийн төлөө байлын судалгаа’-ны тайланд баатасан.

4.1 ХӨДӨӨ АЖ АХҮЙ, МАЛ АЖ АХҮЙ, ОЙН АЖ АХҮЙ

Хөдөө аж ахуйн салбар Монголын нийт ДНБ-ий 14.8%-ийг үйлдвэрлэдэг бөгөөд экспортын орлогын 0.7%-ийг бүрдүүлж, нийт ажиллах хүчний 35%-ийг ажлын байраар хангагдад.

Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллогоор 2455 аж ахуйн ногж тус салбарт бүртгэгдсэн байсан бөгөөд 403.5 мянган хүнийг ажлын байраар хангаж байв. Нийт бүртгэгдсэн аж ахуйн нэгжээс 507 нь мал аж ахуй, 1,705 нь газар тариалан, 243 нь ойн аж ахуй, ан агнуур, загас агнуурын салбарт үйл ажиллагаа явуулж байжээ. Хөдөө аж ахуйн салбар дахь ажлын байрны 84.9%-ийг мал аж ахуй, 14.5%-ийг газар тариалан, 0.6%-ийг ойн аж ахуй, ан агнуур болон загас агнуурын салбар хангаж байв¹⁸.

МАЛ АЖ АХҮЙ

Нүүдлийн малчид нь гэр булийн хамт нүүдлийн мал аж ахуй эрхлэн, өрхийн орлогын эх үүсвэрээ бүрдүүлдэг хүмүүс юм. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, үйлдвэрлэлийн менежменттэй холбоотой тэдний харилцаа нь гэр булийн түвшинд явагддаг. Тухайн өрхийн малын тоо толгой, үр өгөөж, гэр булийн гишүүдийн тооноос хамаараад хэн нь ч ажил олгогч буюу ажилтан байж болно. Нүүдлийн малчдын амьжиргаа нь байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шууд хамааралтай учир өндөр эрсдэлтэй бөгөөд хуримтлал үүсгэх хурд тун бага байдаг. Эдгэр онцлог шинж чанар нь хөдөлмөрийн тусгайлсан зохицуулалтыг шаардах байгаа юм.

Өмнө дурдсанчлан, хөдөө аж ахуйн салбар нь албан бус секторт багтдаггүй бөгөөд малчдыг нэгэн төрлийн хөдөлмөр эрхлэгч гэж үздэг.

МУЗГ-аас малчдад чиглэсэн хэд хэдэн бодлогыг хэрэгжүүлсэн. Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас малчдын орлогын эх үүсвэрийг баталгаажуулах, ажиллах нөхцлийг сайжруулах, даатгалын нөхцлийг өргөжүүлэх, хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахад туслалцаа үзүүлэх зорилготой үндэсний хэмжээний хэд хэдэн бодлого, хөтөлбөрийг авч хэрэгжүүлсэн. Үүнд “Малчдын талаар төрөөс баримтлах бодлого”, “Монгол мал” бодлого, 2009, 2010, 2011 онуудад УИХ-ын 39, 23, 29 дугаар тогтооолоор тус тус батлагдсан “Хөдөө аж ахуйн бирж байгуулах тухай” бодлого зэргийг дурдаж болно. Түүнчлэн МУЗГ-аас “Эрчимжсан мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр” болон Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2013 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны

¹⁸ УСХ 2012: Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллогын үндсэн үр дүн, хуудас 27, 47; ХАА-н салбар дахь хөдөлмөр эрхэлтийн тоон мэдээлэл нь албан статистикаас зөрж байна. Ногоон ажлын байрыг цаашид дэлгэрүүлэн авч үзэхийн тулд тус тооллогын мэдээллийг ашигласан болно.

үндсэн чиглэл зэргийг батлан хэрэгжүүлж байгаа юм.

Өнөөдрийн байдлаар 342.467 орчим хүн мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчиний 32.3%, хөдөө аж ахуйн салбарт ажиллагдын 84.3%-тай тэнцэж байна. Нийт малчдын 43.9% нь эмэгтэй, 56.1% нь эрэгтэй; 340,157 малчин ерхийн хэмжээнд, 2,310 малчин аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлдэг байна. Түүнээс гадна, малаж ахуйн салбарт ажиллаж буй нийт ажиллагдаас 4,881 хүн малын эмч, мал аж ахуйн инженер зэрэг мал аж ахуйн мөргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байна.

Хүснэгт 4.1: Мал аж ахуйн салбар дахь мэргэжилтний тоо

№	Мэргэжилтэн	Нийт	Үүнээс	
			Эр	Эм
1	Малын эмч	438	220	218
2	Мал аж ахуйн инженер	416	213	203
3	Мэргэжлийн фермер	317	165	152
4	Бусад (менежер, нягтлан бодогч, өргөн хэрэглээний барааны мэргэжилтэн г.м.)	3710	2135	1575
	Нийт	4881	2733	2148

Эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллогын үндсэн үр дүн, Хуудас 56, YCX 2012

Ард иргэдийг чанартай хүнсээр хангах зорилго бүхий эрчимжсэн мал ахуйг дэмжих бодлогын үр дүнд эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо 1,706 хүрч өссөн (3.4%-ар өссөн) бөгөөд үүнээс 977 нь сүү, сүүн бүтээгдэхүүний, 78 нь махны үүлдрийн үхрийн, 229 нь мах, ноосны, 181 нь гахайн, 152 нь тахиан, 89 нь зэгийн аж ахуй байв¹⁹.

Зэгийн аж ахуй нь Монголд сүүлийн үед сэргэж байгаа аж ахуйн нэг юм. Зэгийн нь дэлхийн экологийн тэнцвэрийг хангахад чухал үүрэгтэй шавьж бөгөөд байгаль дахь биологийн олон төрөлт байдлыг хадгалахад ээрэг нөлөө үзүүлдэг. Түүнчлэн, зэгийг хөдөө аж ахуйн салбарт өргөнөөр хэрэглэдэг. Тухайлбал, цэцгийн тоос цуглуулахаас гадна зэгийн нь ургамал, тариад тоос хүртээж, экологийн тэнцвэртэй орчинг бүрдүүлэхэд тусалдаг байна. Тийм, ч учир хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй газрын ойр зэгийн үүр байршуулсан байх нь элбэг. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн эхний 10 жилийн хугацаанд зэгийн аж ахуй огцом уналтад орсон. Гэсэн хэдий ч Дэлхийн зөн, Дэлхийн байгаль хамгаалах сан зэрэг олон улсын байгууллагуудын хүчин чармайлтын дунд олон эерэг өөрчлөлтүүд гарч эхлээд байна. Монголын зэгийн үржүүлэгчдийн үйлдвэрлэсэн зэгийн бал нь MYXAUT-ын Ногоон шошгын шалгуурыг хангаад байгаа юм.

Монголын зэгийчдийн нийгэмлэг (МЗН)-ээс 2013 оны 12 дугаар сард Монгол Улсад анх удаа Зэгий

19 YCX 2013: Хөдөө аж ахуйн салбар 2012 онд, Хуудас 28; http://www.mofa.gov.mn/new/images/banners/report/tanilts_livestock.pdf

үржүүлэгчдийн тооллогыг зохион байгуулж явуулсан. Тус тооллогын дунд зэгийн аж ахуйн салбарт ногоон гэж тооцож болох 415 ажлын байр бий гэсэн тооцоо гарсан байна.²⁰

МАЛ АЖ АХУЙН САЛБАР ДАХЬ ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР

Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт төсөл, Мянганы сорилтын сангийн Хот суурин газрын ойролцоо бэлчээрийн менежментийн төсөл, Нидерландын Засгийн газраас санхүүжүүлж буй Газрын тогтвортой менежмент зэрэг олон улсын байгууллагуудаас санхүүжүүлж буй хэд хэдэн төсөл бий. Тэдгээр төслийн хүрээнд малчдад бэлчээрийг удаан хугацаагаар эзэмшиүүлэх, малын тоог бууруулж үржил шимиг өсгөх, эрчимжсэн фермерийн аж ахуй эхлүүлэх, мал сүрэг, газрын эрүүл мэндийг сайжруулах, малцид малын эмчийн хамтын ажиллагааг сайжруулах зэрэг олон арга хэмжээ хэрэгжсэн. Энэ бүх үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчинд ээлтэй аж ахуй эрхлэхэд малчдад туслалцаа үзүүлэх зорилготой юм.

Ургамлын гарц, жил тутмын цаг уурын нөхцөл байдал, нэн ялангуяа хур тунадасын хэмжээнэс хамаараад бэлчээрийн даац харилцан адилгүй байdag. Цаг агаарын нөхцөл сайтай жилийн хувьд Монголын нийт бэлчээрийн даац 82.5 сая толгой мал; дундаж жилд 68.8 сая толгой мал; цаг агаарын нөхцөл тааруу жилд 55.5 сая толгой мал байdag гэсэн тооцоо бий²¹. Үндэсний хэмжээнд 100 га бэлчээрийн дундаж даац нь 60 толгой мал байdag байна.

Статистик мэдээллээс үзвэл 2012 онд Монгол Улс нийт 67.3 сая толгой малтай байсан бөгөөд мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд цаг агаарын нөхцөл байдал таатай байжээ. Тиймээс улсын хэмжээнд бэлчээрийн дундаж даац хэтрээгүй байна.

Малчдын шилжилт хөдөлгөөний улмаас бэлчээрийн даац хэтрэх асуудал голлон хот суурин газрын ойролцоо ажиглагддаг. Тухайлбал, 100 га бэлчээрт ноогдох малын тоогоор Орхон (857 толгой), Улаанбаатар (325 толгой), Дархан-Уул (270 толгой), Булган (180 толгой), Архангай (174 толгой), Сэлэнгэ (141 толгой) аймгууд улсын дунджаас 2.4-14.3 дахин хэтэрсэн байна²². Эдгээр аймаг нийт 89,967 малчдтай бөгөөд энэ судалгаанд тэднийг хүрээлэн буй орчинд ээлтэй ажлын байрны тооноос хассан болно.

Дээрх үндэслэл дээр тулгуурлан дараах 252,915 ажлын байрыг хөдөө аж ахуйн салбар дахь хүрээлэн буй орчинд ээлтэй ажлын байр гэж үзэж болох юм.

20 МЗН 2013: Мэдээ “Зэгийн аж ахуйн үр дүн бэлэн боллоо”, www.mofa.gov.mn/news/see/29

21 А.Бакей, Б.Чимид-Очир 2010: Малчин өрхийн амьжирээ: Нөхөнээс хүчин зүйлс, сайжруулах арга зам, Хуудас 10, <http://www.maas.edu.mn>

22 YCX 2013: Хөдөө аж ахуйн салбар 2012 онд, Хуудас 29 http://www.mofa.gov.mn/new/images/banners/report/tanilts_livestock.pdf

Үүнд:

- Зөгий үржүүлэгчид -415
- МАА салбар дахь мэргэжлийн ажилчид-4,881
- Малчид -247,619

МАЛ АЖ АХҮЙН САЛБАР ДАХЬ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Мал аж ахуйн салбар дахь хөдөлмөр эрхлэлт нь ихэвчлэн өрхийн хүрээнд байдаг. Хэдийгээр мал сүргийн тоо толгой олон малчид туслах малчин авч ажиллуулан, ажлын байр бий болгож байгаа хэдий ч малчдын ихэнх нь нийгмийн даатгалд хамрагдаагүй байдаг бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй байна. Түүнчлэн туслах малчдын ихэнх нь бэлэн мөнгөөр бус эд бараагаар цалинждаг аж.

Нийт малчин өрхийн 19.1% буюу 40,000 хүн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 84.4% буюу 176,800 хүн эрүүл мэндийн даатгалын хураамж төлсөн байна²³. Түүнчлэн, аж ахуйн нэгжид ажиллагч 2,310 орон тооны ажилтан нийгмийн болон эрүүл мэндийндаатгалхамрагдсан бөгөөдөрт дунджаар 9.25 цаг ажилладаг байна²⁴. Мөн мал аж ахуйн салбарт мэргэжлийн 4,881 ажилтан ажилладгаас 202 нь төрийн болон хувийн хэвлэлийн байгууллагад ажилладаг бөгөөд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдажээ. Үлдсэн мэргэжлийн ажилтнууд хувиараа хөдөлмөр эрхлэдэг бөгөөд тэдний ажлын нөхцлийн талаар ямар нэг мэдээлэл байхгүй байна. Түүнчлэн, зөгий үржүүлэгчдийн нийгмийн даатгалын төлбөрийн талаар мэдээлэл байхгүй байлаа.

МАЛ АЖ АХҮЙ ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Тиймээс зөвхөн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн малчид болон аж ахуйн нэгжид ажилладаг мэргэжлийн ажилчид нийлсэн 42,512 ажлын байрыг зохиустой хөдөлмөр эрхлэлт хэмээн үзэж болох юм. Мөн дээрх үндэслэл дээр тулгуурлан үзвэл мал аж ахуйн салбар дахь 42,512 ажлын байрыг ногоон ажлын байр хэмээн үзэж болох юм:

- Нийгмийн даатгалд хамрагдсан малчид- 40,000
- Малчин- аж ахуйн нэгжийн орон тооны ажилтан -2,310
- Мал аж ахуйн салбар дахь мэргэжлийн ажилтан- 202

ГАЗАР ТАРИАЛАН

Тариалан эрхлэх боломжтой газар нутгийн хэмжээ 2012 онд 115.4 сая га байсан нь өмнөх

²³ УСХ 2012: Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдуугаар тооллогын үндсэн үр дүн, хуудас 35, 273

²⁴ Мөн адил.

оныхоос 0.1 сая га буюу 0.1%-иар буурсан үзүүлэлт юм. Үүнээс, 96.2% нь бэлчээр, 1.5% нь малын тэжээлийн тариалан буюу хадлангийн талбай бөгөөд 0.9% нь бусад төрлийн тариалан байв.

2013 оны байдлаар тариалангийн талбайн 70.43%-д улаан буудай, 20.0%-д тосны ургамал буюу ихэвчлэн рапс, 3.7%-д төмс, 2.1%-д хүнсний бусад ногоо, 2.7%-д малын тэжээл тарьсан байв²⁵.

Газар тариалангийн салбарт нийт 117,477 хүн ажиллаж байгаагийн 58,447 нь байнгын буюу орон тооны, 37,871 нь цагийн, 15,254 нь улирлын шинхтэй хөдөлмөр эрхлэлт байна. Түүнчлэн, энэ салбарт хөдөлмөр эрхлэгчдийн 5,905 мянга нь мэргэжлийн ажилчид байгаа юм²⁶. Орон тооны 58,447 ажилчны 87.1% нь өрхийн үйлдвэрлэлд, 12.9% буюу 7,532 нь аж ахуйн нэгжид ажиллаж байна.

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ БАРИМТАЛЖ БҮЙ ТӨРИЙН БОДЛОГО

МУЗГ-аас баримталж буй гол бодлогын нэг нь хүн амыг дотооддоо үйлдвэрлэсэн эрүүл, аюулгүй, чанартай хүнсээр хангах явдал юм. Тухайлбал, МУЗГ-ын 2012-2016 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн 95 дахь заалтад “Баруун бүсийн газар тариаланг хөгжүүлэх замаар тус бус нутгийн хүн амын хүнсний нийлүүлэлтийг сайжруулах” зорилт дэвшигүүлсэн бөгөөд “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн 14.7 дахь заалтад “Баруун болон зүүн бүсэд, эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг сэргээн хөгжүүлэх, түүний дотор Халх голын бус нутагт тариалангийн зориулалтаар ашиглаж болох атаршсан болон атар газрыг эргэлтэд оруулах зорилго бүхий “Халх гол” төслийг хэрэгжүүлэх” гэж тусгажээ.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас хүлэмжийн тариалан эрхлэдэг өрхөд дэмжлэг үзүүлдэг бөгөөд, хүлэмжийн аж ахуйг хөрсийг хамгаалалтад авсан хэлбэр хэмээн үздэг юм. Засгийн газрын санхүүжилтээр 2007-2012 оны хооронд Солонгосын өндөр технологийн 2,454 хүлэмж худалдаж авсан бөгөөд 1,250 иргэн, аж ахуйн нэгжийг хүлэмжийн удирдлага, менежментийн талаар сургалтад харуулсны үндсэн дээр тараан өгчээ. Хүлээн авагчид нь нийт зардлын 50%-ийг төлсөн байна²⁷.

Хөдөө аж ахуйн тооллогос үзүүлэл 6,437 өрх, 804 аж ахуйн нэгж хүлэмж ажиллуулахын зэрэгцээ агуулах, зорьж зэрэг хөдөө аж ахуйн бусад байгууламж эзэмшдэг аж. (Хүснэгт 4.2-ыг үз)

²⁵ УХААЯА 2013: “Цаг үеийн мэдээлэл” бүлэгтэй №. 2013/04, хуудас 16 <http://www.mofa.gov.mn/new/images/banners/reporttu04.pdf>

²⁶ УСХ 2012: Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдуугаар тооллогын үндсэн үр дүн, хуудас 35, 59

²⁷ УХААЯА 2013: 2007-2012 онд хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, http://mofa.gov.mn/new/index.php?option=com_content&view=article&id=71&Itemid=155

Хүснэгт 4.2: Хүлэмж ажиллуулахын зэрэгцээ агуулах, зоорь, гараж зэрэг хөдөө аж ахуйн бусад байгууламж эзэмшдэг өрх, аж ахуйн нэгжийн тоо, 2011

ХАА-н байгууламж эзэмшдэг нийт өрх	6,437	ХАА-н байгууламж эзэмшдэг нийт аж ахуйн нэгж	804
Хүлэмжтэй	1,428	Хүлэмжтэй	199
Агуулахтай	125	Агуулахтай	305
Зоорьтой	5,421	Зоорьтой	395
Үр тариа хадгалах савтай	15	Үр тариа хадгалах савтай	142
ХАА-н машин төхөөрөмжийн гараж	211	ХАА-н машин төхөөрөмжийн гараж	109
		Машин тоног төхөөрөмж засварлах	60

Эх сурвалж: YCX 2012: Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдуугаар тооллогын үндсэн үр дүн

Гэвч энэ салбар дахь ажлын байрны талаар дээрхээс өөр албан ёсны мэдээлэл олдоогүй болно.



Хөдөө аж ахуйн салбарт ногоон эдийн засагт төвлөрч хэрэгжүүлсэн нэгсанаачилга бол "Ногоон ажлын байр-

Чацаргана" үндэсний хөтөлбөр юм.

"Ногоон ажлын байр-Чацаргана" үндэсний хөтөлбөрийн хүрээнд 620 га газарт хүрэлцэх чацарганы суулгац тариалж, 215.6 га газрыг элсний нүүдлээс хамгаалж, уул уурхайгаас орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийсэн ба 4,591 ногоон ажлын байр бий болгожээ. Тэдгээр нь бүгд чацаргана тариалагчид юм. MYXAYT-ын "Органик Монголд үйлдвэрлэв" санаачилгын хүрээнд чацарганы тос, шүүс гэсэн бүтээгдэхүүнүүдэд ногоон шошго олгосон байна.

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАР ДАХЬ ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР

"Ногоон ажлын байр-Чацаргана" үндэсний хөтөлбөрийн хүрээнд бий болсон нийт 4,591 ажлын байрын хүрээлэн бүй орчинд ээлтэй гэж үзэж болно.

Улмаар, хүлэмжийн аж ахуйн эрхэлдэг, агуулахын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд нь хүрээлэн бүй орчинд хор хохирол учруулдаггүй учир эдгээр салбарт бий болж буй ажлын байрыг мөн хүрээлэн бүй орчинд ээлтэй гэж үзэж болно. Гэхдээ ямар хэмжээний ажлын байр бий болсон талаар мэдээлэл байхгүй юм.

Газар тариаланд ашиглагдаж буй нийт газар нутгийн 61.9% нь хөрсний гэмтэлтэй бөгөөд, га тутмын гарц доогуур байдаг учир энэ салбар дахь бусад ажлын байрыг хүрээлэн бүй орчинд ээлтэй гэж үзэх боломжгүй. Гарцыг нэмэгдүүлэхийн тулд олон аж ахуйн нэгж химийн бордоо ашигладаг. 2011 онд гэхэд хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй

газар нутгийн га тутамд 1.1 тонн бордоо ашиглагдсан бөгөөд га тутамд 0.9 кг химийн бодисыг хортон шавьж устгах зориулалтаар ашигласан гэсэн тооцоо бий.

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАР ДАХЬ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхлэгсэд бүгд (7,532) нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бол, өрхийн бизнест ажиллагсдын 40% (13.4 мянган хүн) нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтэл төлдөг байна. Тиймээс эдгээрийг зохистой хөдөлмөр эрхлэлт гэж үзэж болох юм. Харин цагийн болон улирлын хөдөлмөр эрхлэлт нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагддаг талаар баримт байхгүй учир тэдгээрийг зохистой хөдөлмөр эрхлэлтэд хамруулах боломжгүй. Түүнчлэн, чацаргана тариалагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэх талаар мэдээлэл байхгүй байлаа.

Иймд газар тариалангийн салбарт зохистой хөдөлмөр эрхлэлт гэж тооцож болох 20,932 ажлын байр байв.

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАР ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Хэдийгээр энэ салбарт хүрээлэн буй орчинд ээлтэй ажлын байр бий ч, тэдгээр нь зохистой хөдөлмөрэрхэллтийншалгуурыг хангахгүй байсан бол эргээд зохистой хөдөлмөр эрхлэлт гэж тооцож болох ажлын байрыг хүрээлэн буй орчинд ээлтэй гэж үзэх боломжгүй байв. Тиймээс энэ судалгааны шалгuur үзүүлэлтгүүдийн хүрээнд, газар тариалангийн салбар дахь ногоон ажлын байрны тооцоог гаргаж чадаагүй болно. Үүнийг тодруулахын тулд илүү нарийвчилсан, асуудал тус бүрээр тусгайлан авч үзсэн судалгааг цаашид гүйцэтгэх нь үр дүнтэй болох нь харагдаж байна.

ОЙН САЛБАР, ЗАГАС АГНУУР

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 11.9% буюу 18,565.6 мянган га газрыг ойн бүрхүүл эзэлдэг гэсэн тооцоо бий. Үүнээс 75.4% нь нарс буюу шилмүүст ой бол 24.6% нь голдуу бутлаг ургамлаас бүрдсэн байдаг (заг, *Haloxylonaphyllum*) байна.

- Ой аж ахуйн хэд хэдэн бэрхшээл тулгараад буй. Бидэнд олдсон мэдээллээр бол 1,475.5 мянган га ойн 32.6 мянган га нь хатаж үхэжсэн, 18.5 мянган га орчин нь унасан гэсэн тоо байна. Улмаар, 123.3 мянган га ойд оновчтой менежмент, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, 365.3 мянган га-д шинээр мод суулгах, 338.1 мянган га-д модны ургалтыг дэмжих, 24.2 мянган га шинэ ойг хамгаалах шаардлагатай байна.

Дэлхийн банкнаас 2002 явуулсан тооллогын дүнд 1950-1980 онд нийт 1.6 сая га, 1999-2000 онд нийт 660 мянган га ой устжээ. Монголын модны жилийн дундаж хэрэглээ нь 1-4 сая шоо метрийн хооронд хэлбэлздэг. Ойн газраас авсан мэдээллээр бол жилд дунджаар 345 мянгаас 2.4 сая шоо метр мод хууль бусаар бэлтгэдэг байна.

ОЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

МУЗ 2001 оны 208 тоот тогтоолоороо Ойн тухай үндэсний хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөр нь хэрэгжилтийн 3 шаттай: Нэгдүгээр үе шат буюу 2001-2005 он, Хоёрдугаар үе шат буюу 2006-2010 он, Гурвадугаар үе шат буюу 2011-2015 он.

Тус хөтөлбөрийн зорилго нь экологийн тэнцвэр, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлж байгаль орчин, ойн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход оршино.

ОЙН САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Өнөөгийн байдлаар ойн салбарт 232 аж ахуйн нэгж ажиллаж байгаагаас 202 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс 106 нь мод, ургамлын суулгац тарьдаг бөгөөд 92 нь мод арчлах хүлэмжийн байгууламжтай аж.²⁸ Цаашилбал 43 аж ахуйн нэгж мод бэлтгэл, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулдаг бөгөөд, 75 нь ойн цэвэрлэгээ, арчилгаа, 164 нь ойн үргүүлэг, 15 нь бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг байна.

Ойн салбарт 2011 оны байдлаар 148 хүн удирдлага, зохион байгуулалтын албантушаалд, 2456 хүн ажилтнаар хөдөлмөр эрхэлж байв. Ажиллагдын тоо 2012 онд 356 хүнээр нэмэгдэж 2812²⁹ хүрсэн ба үүнд мод суулгадаг 442 ажилтан, ойн цэвэрлэгээ, арчилгаа эрхэлсэн 1996 болон 372 туслах ажилтан багтаж байна.

Үүний зэрэгцээ, улсын хэмжээнд энэ салбарт 336 улсын байцаагч (сумд бүрт 1 улсын байцаагч), 775 байгаль хамгаалагч ажиллаж байв.

Дээр дурдсан хөдөлмөр эрхлэлтээс гадна 565 өрх мод үргүүлгийн хүлэмжтэй бөгөөд 5,317 өрх мод суулгах ажиллагаа явуулж байжээ. Тэдний зарим нь ой ашиглагчдын бүлэгт нэгдсэн байна. Өнөөгийн байдлаар ой ашиглагчдын 600 бүлэг байдаг гэсэн тоо бий ч хэдэн ажлын байр бий болгосон талаар мэдээлэл байхгүй байна.

²⁸ УСХ 2012: Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллогын үндсэн үр дүн, хуудас 228-229

²⁹ УСХ 2012: Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллогын үндсэн үр дүн, хуудас 4

ОЙН САЛБАР ДАХЬ ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР

Уг салбарт нийт 3,923 ажлын байр байгаагийн 2,812 нь ойн компаниудын ажилтан; 336 нь улсын байцаач, 775 нь байгаль хамгаалагч бөгөөд тэднийг хүрээлэн бүй орчинд ээлтэй ажлын байр хэмээн үзэж болно.

ОЙН САЛБАР ДАХЬ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Ойн салбарын нийт зардлын 25% (746.7 сая төг)-ийг ажилдын цалин хөлсөнд зарцуулсан бөгөөд УСХ-ны мэдээллийн дагуу 2012 онд хөдөө аж ахуй, ой, загас, ан агуурын салбарын ажилчны дундаж цалин 244,200 төг байсан байна.

Улсын байцаач, байгаль хамгаалагч нийлсэн 1,111 ажлын байр нь ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ хийсэн, хуулиар тогтоосон хөдөлмөрийн хөлслний доод хэмжээнээс дээгүүр цалинтай, нийгэм, эрүүл мэндийн даатгалд хамрагддаг учир зохистой хөдөлмөр эрхлэлт гэж үзэж болно.

Аж ахуйн нэгжүүдийн бий болгож буй ажлын байрыг удирдлагын түвшний болон хүлэмжийн цөөн хэдэн ажлын байрыг эс тооцвол улирлын чанартай хөдөлмөр эрхлэлт гэж үзэж болох юм. Гэсэн хэдий ч УСХ-ноос гаргасан тодорхойлолтын дагуу тэдгээрийг орон тооны буюу байнгын ажлын байр гэж тооцож болох аж.³⁰ Иймд ойн салбар дахь нийт 3,923 ажлын байрыг бүгдийг зохистой хөдөлмөр эрхлэлт гэж үзэж болох юм.

ОЙН САЛБАР ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Хүрээлэн бүй орчинд ээлтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийн шаардлагыг хангаж буй 3,923 ажлын байрыг ногоон ажлын байр гэж үзэж болно.

ЗАГАС АГНУУРЫН САЛБАР ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллогын үндсэн үр дүн, хуудас 228-229

Хөдөө аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 106 байнгын ажлын байр бий болгосны 26.2% нь эмэгтэйчүүд байна³¹. Гэвч загас агуурын салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг нууцалсан байсан тул энэ салбар дахь ногоон ажлын байрны талаар тооцоо гаргах боломжгүй байлаа.

²⁸ УСХ-ноосгаргасантодорхойлолтындаагуу: "Байнгынажилттангээдээс нь байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тоогтоомжкоор зохицуулагддаг иргэнийн хэлнэ".

²⁹ УСХ 2012: Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллогын үндсэн үр дүн, хуудас 4

4.2 ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР

Монгол Улсын эдийн засгийн ёсөлттэй зэрэгцэн эрчим хүчиний эрэлт нэмэгдэх байна. Тус салбар 2012 онд ДНБ-ий 6%-ийг эзэлж байсан ба 2009 онтой харьцуулахад эрчим хүчиний үйлдвэрлэл 48.6%-ар өссөн байв. Эрчим хүчиний эрэлтийн хувьд, нийт эрэлтийн 62.7% нь аж үйлдвэр, барилгын салбарын, 24.3% нь өрхийн, 4.2% нь тээвэр, харилцаа холбооны, 0.1% нь хөдөө аж ахуйн, 8.9% нь бусад салбарын хэрэглээнээс үүдэлтэй байв³².

Нийлуулэлтийн талаас бол нийт эрчим хүчиний 90.6%-ийн дулааны цахилгаан станц, 1%-ийг усан цахилгаан станц, 0.55%-ийг дизель цахилгаан үүсгүүрээс гаргаж авдаг ба 7.85%-ийг импортодлог байна. Түүнчлэн, 2020 он гэхэд эрчим хүчиний хэрэглээ өнөөгийн түвшнээс 2-3 дахин нэмэгдэх төлөвтэй байна. Өнөөдөр эрчим хүч үйлдвэрлэлийн чадавх доогуур байгаагас үүдэн 2013 онд шинээр баригдсан 100 орчим барилга төв халаалтын шугамтай холбогдож чадаагүй байна.

Өнөөгийн байдлаар эрчим хүчиний салбарт 14.5 мянга орчим хүн ажиллаж байгаа нь 2009 онтой харьцуулахад 51.9%-ар нэмэгдсэн тоо юм. Энэ нь улсын хэмжээн дэх нийт ажиллах хүчиний 14.5%-тай тэнцэж байна. Салбарын хэмжээнд ажиллагдснын 11.3% нь цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын удирдлагын түвшинд ажиллаж байгаа бол 29.4% нь инженер техникийн ажилтан, 68.1% нь дулааны цахилгаан станцын ажилтан бөгөөд 12.7% нь туслах ажилтнууд байна³³.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

МУЗГ-аас эрчим хүчиний салбарт баримталж буй стратегийг дараах 3 үндсэн чиглэлд хувааж болно:

1. Эрчим хүчиний шинэ эх үүсвэрийг бий болгож; орон нутгийн/бүс нутгийн эрчим хүчиний сүлжээг ашиглалтад оруулах;
2. Татвараас хөнгөлөх, чөлөөлөх, түүнчлэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар сэргээгдэх эрчим хүчиний үйлдвэрлэлийг дэмжих; 2020 он гэхэд “нийт эрчим хүчиний хэрэглээний 20%-ийг сэргээгдэх эх үүсвэрээр гаргаж авах” зорилго дэвшүүлээд байна.
3. Нүүрс, байгалийн хийг ашиглах шинэ технологи боловсруулах, инновацийг дэмжих.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР ДАХЬ ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР

Судалгааны баг сэргээгдэх эрчим хүчиний салбарт бий болж буй бүх ажлын байрыг хүрээлэн буй орчинд ээлтэй гэж үзсэн. Өнөөгийн байдлаар Монголд сэргээгдэх эрчим хүчиний салбар нь салхи, нар, усны

³² www.mree.mn/index.php?pid=2

³³ УСХ 2013: 2012 оны Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

эрчим хүчийг ашигладаг цахилгаан станцуудаас бүрдэж байна.

Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, турших, үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 12 компани, 1 хүрээнд бий. Түүнчлэн, өнөөгийн байдлаар 2 салхин станц бий бөгөөд үүний нэг нь Дорноговь аймгийн Хатанбулаг суманд бий бол нөгөө нь Төв аймгийн Сэргэлэн сум дахь “Салхит” станц (50 MB) юм. Энэ хоёр цахилгаан станц дахь ажлын байрны тоог дээр дурдсан 639 ажлын байранд багтаасан болно.

Мөн нийт 100 кВ цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай 8 нарны цахилгаан станц Өмнөговь (1), Говь-Алтай (3), Баянхонгор (1), Баян-Өлгий (3) аймгуудад бий бөгөөд нийт 150-200 кВ хүчин чадалтай нар, салхины хосолсон 3 цахилгаан станц бий³⁴. Эдгээр цахилгаан станцууд дахь хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдээлэл байхгүй болно. Гэсэн хэдий ч албан бус эх үүсвэрээс авсан мэдээллээр Баянхонгор аймгийн Шинэ жинст сумын нутаг дэвсгэр дээрх цахилгаан станц 150 кВ хүртэлх эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 2 ажилтантай аж.

Түүнчлэн 11 кВ-2000кВ хүчин чадалтай 11 усан цахилгаан станц байгаа ба нийт 137 ажлын байр бий болгожээ³⁵.

Засгийн газраас хэрэгжүүлсэн “100 мянган нарны гэр” үндэсний хөтөлбөр нь өөрөө шууд ажлын байр бий болгоогүй. Харин худалдаа эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагууд нарны эрчим хүчиний хавтан импортлохын зэрэгцээ засвар үйлчилгээ хийж эхэлсэн байна. Жишээлбэл, эдгээр компаниудын нэг нь “Малчин ХХК” юм. Тус компани нь 2013 оны 12 дугаар сард БОНХЯ-аас шалгаруулдаг “Гранпри шагналт байгууллага” болон “Сэргээгдэх эрчим хүч нэвтрүүлэгч байгууллага”-аар тодорсон байна³⁶. “Малчин” ХХК нь нарны энергийр ажилладаг гэр ахуйн бүх төрлийн цахилгаан бараа зэрэг байгаль орчинд ээлтэй, хамгийн сүүлийн үеийн технологиор үйлдвэрлэгдсэн, Европын стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг малчдад нийлүүлэхийн зэрэгцээ 18 хүнийг ажлын байраар хангагдад байна. Хувийн хэвшлийн бусад аж ахуйн нэгжийн мэдээллийг авах боломжгүй байлаа.

Түүнчлэн, эрчим хүчиний альтернатив эх үүсвэрийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг учир, нүүрс, байгалийн хийн зохистой хэрэглээтэй холбоотой аливаа ажлыг ногоон ажил гэж тооцож болох юм.

³⁴ ЭХЗЗ 2013: Монгол Улсын нутаг дээсээр дээр ажиллаж байгаа сэргээдэх эрчим хүчиний зарим станцууд, www.erc.mn/mn/renewable_energy

³⁵ Отгончимэг, Гео-экологийн судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээнээс ажилтан

³⁶ Дэлхийн ногоон байгаль (GWE) ТББ 2013: Шилдэг ногоон шагнал-2013, www.gwe.mn/medee/baigal-orchnii-salbariin-medee/1663-best-green-awards/2013.html

Монгол Улсад шингэрүүлсэн хийг хот суурин газар хийгээд хөдөө орон нутгийн өрхийн болон аж ахуйн нэгжийн эрчим хүчний эх үүсвэр болгон нэвтрүүлэх, халаалтад ашиглах, автомашины тулш болгон ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 6 компани бий. “Дашваанжил ХХК” нь тэдний нэг бөгөөд БОНХЯ-аас “Байгальд зэлтэй технологийг дэлгэрүүлэгч байгууллага”-аар тодруулжээ³⁷. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулагч компаниуд нийтдээ 437 ажилтантай байна³⁸.

Түүнчлэн, хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нүүрснээс шахмал тулш гарган авах үйл ажиллагаа явагддаг хэдий ч харамсалтай нь үүнтэй холбогдох ажлын байрны талаар мэдээлэл байхгүй байна.

Тиймээс энэ салбарыг ойролцоогоор 1,231 ажлын байрыг хүрээлэн буй орчинд зэлтэй гэж тооцож болох юм.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР ДАХЬ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Эрчим хүчний салбарын ажилтны дундаж цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс өндөр бөгөөд ажиллагсад нийтээрээ нийгмийн даатгалд хамрагдаж ажлын хувцас, ажлын байран дээрх хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ болон хоолны нэмэгдэл авдаг байна.

Хүснэгт 4.3: Эрчим хүчний салбарт ажиллагсдын сарын дундаж цалин, мянган төгрөгөөр

Он	НД-ын шимтгэл төлсөн хувь	Байнгын ажилтан	Сарын дундаж цалин	Инженер техникийн ажилчдын сарын дундаж цалин
2009	9.5	9.5	297.3	314.3
2010	12.4	12.4	337.5	363.2
2011	11.9	11.9	411.3	430.6
2012	14.5	14.5	540.8	596.8

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2012; YCX

Иймд эрчим хүчний салбар дахь бүх ажлын байрыг зохиристой хөдөлмөр эрхлэлт гэж үзэж болох юм.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Дээрх үндэслэл дээр тулгуурлан сэргээгдэх эрчим хүчний салбарт бий болсон 1,231 ажлын байрыг ногоон ажлын байр гэж тооцсон болно.

4.3 УС, ХАЯГДАЛ УСНЫ МЕНЕЖМЕНТ

УСНЫ НӨӨЦ БОЛОН МЕНЕЖМЕНТ

Монгол орны усны нөөц тун хомс. Монголын нийт газар нутгийн 70% орчимд гадаргын усны нөөц байхгүй бөгөөд газар нутгийн дөнгөж 30%-д гадаргын усны нөөцтэй. Түүнчлэн Монгол орны нутагт бүрэлдэх гол, мөрний усны жилийн дундаж нөөц 30.6 шоо км, ОХУ, БНХАУ-ын нутгаас ирэх урсцыг оролцуулсан тооцвол 34.6 шоо км болно. Гол мөрний бүх усны нөөцийн 49.0%-ийг /16.9 шоо км/ Хойд мөсөн далайн ай сав, 11%-ийг /3.80 шоо км/ Номхон далайн ай сав, 40%-ийг /13.9 шоо км/ Төв Азийн гадагш урсацгүй ай савын гол горхины ураац эзэнэ.

Гол мөрний жилийн дундаж урсцын 60% нь гадагш хил даван урсаж, үлдэх хувь нь хөрсөнд нэвчиж, газрын доорх усиг тэжээх буюу говийн нууру уداد цутгана. Усны нөөцийн 83.7%-ийг нуур, 10.5%-ийг мөсөн гол, 5.8%-ийг голын ус тус тус эзэнэ. Гадаргын усны нөөцийн 85%-ийг цэнгэг ус, түүний түүний 93.6%-ийг нутгийн баруун хэсэгт байрлах Хөвсгөл нуурын ус эзэнэ. Монголын эрдэмтэд, усны мэргэжилтнүүд усны 29 ай савыг олж тогтоосон ба нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд усны оновчтой менежментийг нэвтрүүлэх шаардлагатай юм. Түүнчлэн, Усны тухай хуулийг УИХ-аас баталсан бөгөөд усны ай сав газрын 23 захиргааны нэгжийг байгуулсан байна. Гүний ус Монгол орны усны нөөцийн 90%-ийг бүрдүүлдэг байна.

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ АСУУДЛУУД

Усны тухай хуулийн дагуу дүүрэг, сум, аймаг, нийслэл жилд нэг удаа, улсын хэмжээнд 4 жилд нэг удаа усны эх үүсвэр, тэдний нөөц, чанар, ашиглалт, хаягдал усны хэмжээний бүртгэл хийнэ гэж заажээ Энэхүү бүртгэлийн зардлыг улсын төсвөөс гаргах аж.

Үүнийдагуу 2011 онд хийгдсэн бүртгэлийн дүнгээр 6,646 гол, горхи тоологдонон 551 нь ширгэсэн, газар доогуур орсон, эсвэл ууршсан байна. Мөн нийт 3,613 нуур тоологдонон 483 нь ширгэсэн; 9,320 булаг бүртгэгдсэнээс 7,441 нь устай тоологдсон байна³⁹. 2007 оноос хойш нийт 2,913 гол горхи, булаг шанд, нуур цөөрөм янз бүрийн шалтгааны улмаас ширгэж үгүй болжээ. Усны нөөцийн хомсдолтой орны хувьд өнөөдөр тулгарч буй хамгийн ноцтой асуудлуудын нэг энэ мөн.

ТӨРӨӨС УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

УИХ-ын 24 тоот тогтоолоор 2010 онд “Ус” Үндэсний хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөр нь

³⁷ Шатахууны мэдээллийн төв сан 2013, www.petroleum.mn/en/companies/hiiin-companys/181-2011-04-12-08-45.html

³⁸ YCX 2013: 2012 оны хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

³⁹ www.nso.mn/content/96072.shtml.

хоёр үе шаттайгаар 2010-2021 оны хооронд хэрэгжих бөгөөд усны ай сав газрын захиргаа байгуулж ажиллуулах, уул уурхайн хаягдал усыг дахин боловсруулж аж үйлдвэрийн зориулалтаар ашиглах зэрэг зорилтуудыг дэвшиүүлжээ. Энэ хөтөлбөрийн үр дүнд, Энержи Ресурс ХХК хаягдал усныахаа 95%-ийг дахин ашиглаж эхэлсэн ба Оюу толгой ХХК-д хаягдал усныахаа дор хаяж 80%-ийг дахин ашиглах шаардлага тавьж эхэлсэн байна.

УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН САЛБАР ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Усны менежментийн салбар ойролцоогоор 1,860 хүнийг байнгын ажлын байраар хангадаг бөгөөд, тухайлбал Ерөнхий сайдын тэргүүлсэн Усны үндэсний хорооны ажлын алба 7 хүний бүрэлдэхүүнтэй; тус хорооны аймаг нийслэлийн засаг даргаар ахлуулсан 21 салбар хороо тус бүр дор хаяж 1 ажилтантай (нийт 21 хүн)⁴⁰; Улаанбаатар хотын Ус, сувгийн удирдах газар (УСУГ) 1488 ажилтантай⁴¹, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар усны асуудал хариуцсан 30 байцаагчтай (аймаг тутамд болон УБ хотын дүүрэг тус бүрийг хариуцсан 1 байцаагч, дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй), БОНХ-ийн сайдын А-78 тоот тушаалаар байгуулагдсан Усны сав газрын удирдлага (30) ойролцоогоор 176 ажилтантай⁴² бөгөөд Ус, цаг уур, орчны хүрээлэн нь усны нөөцийн биологийн болон химийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр 138 хүн ажиллуулдаг байна⁴³.

Удирдлага зохицуулалтаар хангах дээрх байгууллагуудаас гадна хот суурин газрын ус түгээлтийн чиглэлээр 4,502 ажлын байр байдаг ба үүний 3,133 нь орон сууцны усан хангамжийг хариуцсан төв сүлжээний ажилчид, 1,369 нь гэр хорооллын устүгээлтийн төвийн бус шугам сүлжээний ажилчид байна⁴⁴.

Түүнчлэн усны менежмент, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон тооны ТББ, төсөл хөтөлбөрүүд бий. Гэхдээ эдгээр нэгжүүд дэх ажлын байрны талаар мэдээлэл байхгүй.

УС ХАНГАМЖИЙН МЕНЕЖМЕНТ ДЭХ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Бүх ажлын байр нь байнгын бөгөөд засгийн газрын агентлагуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд суурилсан байна. Тиймээс нийт 6,362 ажлын байрыг зохистой хөдөлмөр эрхлэлт гэж үзэж болно.

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР

Усны хангамжийн салбар дахь гэр хорооллын ус түгээлтийн холбоотойгоос бусад бүх ажлыг хүрээлэн бүй орчинд ээлтэй ажлын байр гэж үзэж болно. Гэр хороолол дахь усны түгээлтэд хэд хэдэн шүүмжлэлтэй асуудал бий. Тухайлбал, эхний бөгөөд хамгийн ноцтой асуудал нь усны чанар бөгөөд үнэ өртөг; хоёрдугаарт, гүний худгудууд нь төв дэд бүтцэд холбогдоогүй байдаг явдал, гуравдугаарт өвлийн улиралд ус түгээгүүрийн цэгүүдийг халаах шаардлагатай байдаг зэрэг болно. Тиймээс, гэр хорооллын оршин суугчдыг төвийн усан хангамжтай холбох зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Дээрх үндэслэлүүдээс үзвэл, нийт 4,993 ажлын байрыг хүрээлэн бүй орчинд ээлтэй ажлын байр гэж үзэж болохоор байна.

УС ХАНГАМЖИЙН МЕНЕЖМЕНТ ДЭХ НОГООН АЖЛЫН БАЙР

Зохистой хөдөлмөр эрхлэлтийн шалгур үзүүлэлтийн хангаж буй, хүрээлэн бүй орчинд ээлтэй 4,993 ажлын байр байна.

ХЯГДАЛ УСНЫ МЕНЕЖМЕНТ БА АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ

Устай холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигч 107 байгууллага байгаагийн 103 нь усны нөөц, ариутгах татуургын ашиглалттай холбоотой бол 4 нь ус олборлох, цэвэршүүлэх байгууламжтай холбоотой. Усны салбарт ажиллагдсан сарын дундаж цалин 508,100 төг байгаа нь хөдөлмөрийн хөлслний доод хэмжээнээс ихээхэн дээгүүр тоо юм.⁴⁵

Дээрх 103 байгууллагаас 66 нь бохир ус цуглуулах, ариутгах, цэвэрлэх барилга байгууламжтай холбоотой байна. Тэдгээр байгууллагууд нь бүгд Хот, суурини ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (ХСУХАТАҮЗЗ)-өөс тусгай зөвшөөрөл авсан аж. Тус зөвлөл нь Хот, суурини ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн дагуу ус цэвэршүүлэх компаний, байгууламжийн стандартыг тогтоох, стандартын хэрэгжилтийг хянах үүрэгтэй юм. Зөвлөлийн бүх үйл ажиллагаа хүрээлэн бүй орчны хамгааллын төвлөвлөгөөтэй нийцэж буй бөгөөд⁴⁶ 176 хүн ажиллуулдаг байна.

Дээр дурдсан байгууллагуудаас гадна Улаанбаатар хотод ус цэвэршүүлэх 46 байгууламж ХСУХАТАҮЗЗ-ийн зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ үндэслэлээр тэднийг ногоон ажлын байранд оруулж тооцоогүй болно.

⁴⁰ БОНХЯ 2014: Монгол орны усны нөөц www.mne.mn/v3/?p=1673#UVGV-PsmWSO

⁴¹ УСУГ: 2013 оны үйл ажиллагааны тайлан, www.usug.ub.gov.mn/index.php/mega-taipei/2012-07-30-0526-22/321-taipei2013

⁴² Усны сав газрын үндэсний зөвлөлдөх уулзалт, Улаанбаатар, 2013 оны 12 дугаар сарын 18-19

⁴³ Д.Төмөрцожж 2013: Мастер судалгаа "Усны бохирдол, түүний тооцоо"

⁴⁴ УСХ 2013: 2012 оны Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

⁴⁵ ХСУХАТАҮЗЗ 2013: Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлдэх байгууллагуудын 2012 оны балансын тэнцэл, үйл ажиллагааны тайлан, Хуудас 1, www.wscc.mn/2013-11-12-2012on Нээгтгэл.pdf

⁴⁶ Мөн адил

ХАЯГДАЛ УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН САЛБАР ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Зөвлөлийн ажилтан 176 хүн нь хөдөлмөрийн гэрээн дээр тулгуурлаж, байнгын хэлбэрээр ажилладаг бөгөөд тэдний сарын дундаж цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээгүүр байгаа учир зохистой хөдөлмөр эрхлэлт гэж үзэж болох юм.

Хаягдал усны менежмент нь хүрээлэн буй орчны хамгаалалтай холбоотой хамгийн чухал үйл ажиллагааны нэг учир энэ чиглэлээр бий болж буй бүх ажлын байрыг хүрээлэн буй орчинд ээлтэй ажлын байр гэж тооцож болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтүүд дээр тулгуурлан бүх 176 ажлыг Ногоон ажлын байр гэж үзэж болох юм.

УСНЫ НӨӨЦ, ХАЯГДАЛ УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН САЛБАР ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Дараах 5,169 ажлын байрыг ногоон ажлын байр гэж үзэж болно. Үүнд:

1. Усны менежмент, судалгааны хүрээлэнгүүдийн 4,993 ажилтан
2. Бохир ус цуглуулах, ариутгах, цэвэрлэх үйл ажиллагаатай холбоотой 176 ажлын байр

4.4 ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хатуу хог хаягдлын тухай Монгол Улсын хуулийг 2012 онд баталсан. Тус хуулийн дагуу хаягдлыг хатуу болон шингэн гэсэн хоёр ангилалд хуваажээ. Нэг хүн жилд дунджаар хагас тон хатуу, 0.6 шоо метр шингэн хог хаягдал гаргадаг гэсэн тооцоо бий. Нийслэлийн захиргаанаас мөн 1,000 кв.м гудамж, зам, талбай бүрд 0.2 тон орчим хог хаягдал цугларч байдаг гэсэн стандарт тооцоо гаргасан.

Хатуу хог хаягдалцаас, шил, мод, яс, хуванцар, метал, органик болон органик бус хаягдал орно. Мөн ийм хог хаягдлыг найрлаг, бүтцийн хувьд ахуйн болон аюултай хог хаягдал гэж ангилдаг. Аюултай хог хаягдал нь хүн, амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөлүүлчүүлэх болон хөрс, агаарын бохирдол үүсгэх зэрэг байгаль орчин, экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байдаг.

Өнөөгийн байдлаар Улаанбаатар хотын орчимд хогийн төвлөрсөн 3 цэг байгаа бөгөөд хаягдлыг хөрсөөр хучих нөхөн сэргээх арга ашигладаг байна. Улаанбаатар хотоос өдөрт дунджаар 1,100 тон хатуу хог хаягдал гардаг бөгөөд үүний 35-40% нь гялгар уут, хуванцар хог хаягдал байдаг⁴⁷.

2010 оны 10 дугаар сард болсон Хог хаягдал экспортлогчдын холбооны Захирлуудын зөвлөлийн

уулзалтаар Захирлуудын зөвлөлийн бүрэлдэхүүний тоог нэмж 23 болгон, салбарын бүх төлөөлөлд суудал өгсөн ба Холбооны нэрийг “Хоёрдогч түүхий эд боловсруулагчдын холбоо” (ХТЭБХ) болгон өөрчилжээ.

Улаанбаатар хотын захиргаанаас хог хаягдлыг ангилах дадал суулгах зорилгоор өрх бүрт сар тутам 15 ширхэг хогийн уут тараах ажлыг саяхан хэрэгжүүлж эхэлсэн. Энэ арга хэмжээг хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах, энэ талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулах кампанийт ажлын эхний алхам хэмээн харж байгаа ч тэдгээр үйл ажиллагаа өнеөг хүртэл хэрэгжих эхлээгүй байна. Түүнчлэн хогийн уут үйлдвэрлэхд нийслэлийн төсвөөс 5.0 тэрбум төг зарцуулж байгаа хэдий ч хог хаягдлыг ангилалгүй уг уутанд хийж хаяж байгаа хэвээр байгаа юм. Гялгар уутын биозадралын хугацаа 400-500 жил байдаг тул хүрээлэн буй орчинд түйлийн хортой. Эдгээр шалтгааны улмаас дээрх үйл ажиллагааг ногоон ажлын байр бий болгож байгаа гэж тооцоогүй болно.

ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН САЛБАР ДАХЬ ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР

Хатуу хог хаягдлыг цуглуулах, халдвартгүйжүүлэх, боловсруулах чиглэлийн ямар ч ажил нь хүрээлэн буй орчны хамгаалалд ихээхэн хувь нэмэр оруулж байдаг бөгөөд хүрээлэн буй орчинд ээлтэй ажлын байр хэмээн зүй ёсоор тооцогдоно.

MYXAYT-аас саяхан зохион байгуулсан “Байгаль орчинд ээлтэй техник, технологи 2012” үзэсгэлэнд хатуу хог хаягдал боловсруулах үйл ажиллагаа явуулдаг 42 компани оролцжээ⁴⁸. Тэдгээр компанийд хаягдал дугуй, моторын тосноос дизель тулш гаргаж авах, гялгар уутнаас төрөл бүрийн бүтээгдэхүүн гаргаж авах, хаягдал цаас боловсруулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна. Энэ компаниудад нийт 1,401 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчиний 1.3%-тай тэнцэж байгаа бөгөөд чиг үүргийн хувьд дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- Хог хаягдал цуглуулах: 439 ажлын байр
- Хог хаягдал цуглуулах, халдвартгүйжүүлэх: 106 ажлын байр
- Хог хаягдаас хоёрдогч түүхий эд гаргаж авах: 185 ажлын байр
- Хог боловсруулах бусад үйл ажиллагаа: 671 ажлын байр⁴⁹.

Эдгээр ажлын байраас гадна ХТЭБХ нь нийт 15,000 гишүүд, дэмжигчидтэй бөгөөд түүхий эд цуглуулах 192 цэг, боловсруулах 12 үйлдвэр ажиллуулдаг байна. Энэ бүх байгууллагууд Засгийн газар болон ижил тестий ТББ-үүдүн хамгаар хог

⁴⁷ News.mn 2012: “Хог хаягдал ангилах цэгүүдийн үйл ажиллагаатай танилц”, 2012 оны 2 дугаар сарын 29; www.news.mn/content/98670.html

⁴⁸ <http://www.mongolchamber.mn/index.php/home-page/home/2012-08-49>

⁴⁹ YCX 2013: 2012 оны Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

хаягдал боловсруулагчдын хууль эрх зүйн орчинг сайжруулах, эдийн засгийн хөгжлийн таатай орчинг бий болгохыг зорилтоо болгодог.

ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН САЛБАР ДАХЬ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Дээр дурдсан ажилчдын 300 орчим нь нийслэлийн харьяа байгууллагуудын ажилтнууд бөгөөд 2013 онд тэдний сарын цалинг 500.0 төг болгон өсгөсөн нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бараг 1.6 дахин их юм. Түүнчлэн, тэд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан, ажлын дүрэмт хувцастай, ажлын байран дээрээ халуун хоолоор хангагддаг бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтад хамрагддаг байна.

Хувийн хэвшлийн ажилчдын ажиллах нөхцөл, цалин хөлсний талаар нарийвчилсан мэдээлэл байхгүй учир зөвхөн дээрх 300 ажлын байрыг зохистой хөдөлмөр эрхлэлт гэж үзэж байгаа юм. Албан бус секторт тодорхойгүй тооны хог түүгч иргэд байдаг хэдий ч тэдний талаар тоон мэдээлэл өнөөгийн байдлаар байхгүй байна.

ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН САЛБАР ДАХЬ НОГООН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хатуу хог хаягдлын менежментийн салбар дахь 1,401 ажлын байрнаас хүрээлэн буй орчны болон зохистой хөдөлмөр эрхлэлтийн шаардлагыг хангаж буй 300 ажлын байрыг л ногоон гэж үзэх боломжтой юм.

4.5 ТЭЭВРИЙН САЛБАР

Тээврийн салбар нь уул уурхай, хөдөө аж ахуйн дараа орох эдийн засгийн гурав дахь том салбар бөгөөд 2012 оны Статистикийн жилийн тайланд дурдсанаар нийт ДНБ-ий 6.6%-ийг үйлдвэрлэж, 56.1 мянган хүнийг ажлын байраар хангагдаг аж. Өнөөгийн байдлаар нийт ачаа эргэлтийн 73.1% төмөр замаар, 26.8% авто замаар, 0.01% нь агаарын тээврээр хийгдэж байна.

2012 оны Хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд дурдсанаар энэ салбарт нийт 72,9 мянган хүн ажиллаж байгаагаас 20.3% нь төмөр зам, 59.9% нь авто тээвэр, 5.4% нь агаарын тээвэр, 1.2% нь шуудан, 3.3% нь агуулах болон тээврийн туслах үйлчилгээний чиглэлээр хөдөлмөр эрхлэдэг байна.

Шинээр 1,702.3 км засмал зам шинээр байгуулсан бөгөөд, 1000 кв.км газар нутаг тутамд ноогдох засмал замын урт 6.06 км болж нэмэгджээ. Нийт сайжруулсан замын 60.2% нь засмал, 21.8% нь аге хайран, 18% нь сайжруулсан широон зам байна.

Түүнчлэн, 2012 оны мэдээллээс үзвэл Монгол Улсын хэмжээнд нийт 345,473 бүртгэлтэй автомашин

байгаагаас 66.2% нь суудлын, 24.2% нь ачааны машин, 6.3% нь автобус, 3.3% нь тусгай зориулалтын машин байжээ. Сүүлийн 6 жилийн хугацаанд жилд дунджаар 48.1 мянган автомашин импортолсон бөгөөд түүний 61.4% нь автомашин, 27.8% ачааны машин, 4.8% нь автобус, 3.3% нь трактор болон бусад төрлийн тээврийн хэрэгсэл, 2.7% нь уул уурхайн зориулалттай автомашин байсан байна. Мөн ойролцогоор 700,000 хүн жолоодох эрхийн үнэмлэхтэй байна.

Нийт автомашины 5.9% нь 3 хүртэлх жил, 22.9% нь 4-9 жил, 71.2% нь 10-аас дээш жил ашиглагдсан байна (Хавсралт дахь Хүснэгт 7-г үз).

Нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 66.3% буюу 228.9 мянга нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд түүний 8.9% нь нийтийн тээврийн буюу тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл байна. Улаанбаатар хотын оршин сууцдын 60% орчим нь нийтийн тээврээр зорчдог аж.

Улаанбаатар нь дэлхий дээрх хамгийн бохирдолтой хотуудын нэг гэж үздэг. Энэ хотод өдөр дунджаар ДЭМБ-аас тогтоосон стандартас 70-80 дахин их хэмжээний нарийн ширхэгт тоосонцор үүсдэг байна. Улаанбаатарын энэхүү бохирдол нь хөрс, ургамал болон тус хотноо оршин сууцдын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэдгийг харуулсан олон судалгаа бий. Улаанбаатарын агаарын бохирдолын нэг үндсэн шалтгаан нь тээврийн салбар бөгөөд энэ нь хуучин, шатахууны зарцуулалт өндөртэй, ихэвчлэн тортогын шүүр байхгүй, мөн дизель тулш хэрэглэдэг автомашин олон байгаагаас голлон шалтгаалдаг байна.

ТЭЭВРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ ТӨРИЙН БОДЛОГО

Монгол Улсын “Дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”-т агаарын бохирдолыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотод экологийн хувьд цэвэр нийтийн тээврийг нэвтрүүлнэ гэж заажээ. Төрийн бодлогын бас нэгэн чухал баримт бичиг болох “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”-ийн стратегийн зорилтуудын нэг нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулж, хүрээлэн буй орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн, эрчим хүчний салбарын ашигт байдлыг нэмэгдүүлсэн эдийн засгийн хөгжлийг хангах хэмээн заасан байна.

“Метро байгуулах”, “Байгаль орчинд ээлтэй нийтийн тээврийг нэвтрүүлэх”, “Ногоон тээвэр” зэрэг тээврийн салбарын агаарын бохирдолд үзүүлэх нөлөөг бууруулах зорилго бүхий хэд хэдэн санаачилга гарсан бөгөөд тэдгээрт дэвшүүлсэн зорилтууд нь Засгийн газрын хөгжлийн стратеги, хөтөлбөрүүдтэй бүрэн нийцэж байгаа юм.

“Ногоон тээвэр” төслийн зорилго нь нийтийн тээврийн 800 автобус, 1,500 жижиг оврын автобусны

хөдөлгүүрийг шинэчилж, дизель түлшнээс экологийн цэвэр түлшинд шилжүүлснээр гарах утааг бууруулах зорилготой.

Тус төслийг МЗУГ болон Олон улсын ногоон өсөлтийн санаачилга олон улсын байгууллагаас санаачлан хэрэгжүүлж байгаа юм. Тус санаачилгын хүрээнд Монгол Улсад ногоон өсөлтийг дэмжихи хамтын ажиллагаа 2011 оны 11 дүгээр сард Байгаль орчин, аялал жуулчлалын өмнөх сайд тус байгууллагатай ХОСБ-т гарын үсэг зурснаар эхэлжээ.

ТЭЭВРИЙН САЛБАР ДАХЬ ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР

Хэдийгээр улсын хэмжээнд 1-3 жил ашиглагдсан 35,946 автомашин, бензин хэрэглэдэг 11,878 автомашин бий⁵⁰ гэсэн тоон мэдээлэл байгаа ч ямар хэмжээний ажлын байр шинээр бий болсон талаар мэдээлэл байхгүй. Харин төрийн өмчийн “Цахилгаан тээвэр” ХХК дотоодын нийтийн тээвэрт ашиглах зориулалтаар хий болон шатахуунаар ажилладаг саармаг хөдөлгүүр бүхий 2 автобус үйлдвэрлэсэн нь шинээр 6 ажлын байр бий болгожээ.

Төмөр замын тээвэр нь хөрсийг гэмтээдэггүй, биологийн олон төрөлт байдал сэргээр нөлөөлдөггүй учир төмөр замын салбар дахь 12,500 ажлын байрыг мөн хүрээлэн буй орчинд ээлтэй ажлын байр гэж үзэж болох юм.

ТЭЭВРИЙН САЛБАР ДАХЬ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Дараах үйл ажиллагааг зохицой хөдөлмөр эрхлэлтэд хамруулж болно. Үүнд:

- Хот хоорондын тээвэр эрхэлдэг 46 компани байгаа бөгөөд тэд нийтдээ том оврын 262, жижиг оврын 214 автобус болон 413 микроавтобус ашиглаж, 1,193 хүний ажлын байраар хангадаг⁵¹ бөгөөд үүний 1007 нь жолооч, үлдсэн 186 нь менежер, инженер, ахлах ажилтнууд байдаг.
- Хотуудад хувийн хөвшлийн 21 компани, төрийн өмчийн 3 компани 133 чиглэлээр нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг. Тэд нийтдээ 1,100 автобус болон троллейбустай бөгөөд нийт 3,958 хүний ажлын байраар хангадаг байна⁵².
- Санхүүгийн болон дипломат байгууллагууд, мөн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд тээврийн салбарт нийтдээ 20,500 орчим ажлын байршинаар бий болгожээ. Эдгээр байгууллагууд бүгд жолооч ажиллуулдаг учир эдгээр ажлын байрыг зохимжтой хөдөлмөр эрхлэлт гэж үзэж болох юм. Тэдгээр жолооч нар хөдөлмөрийн

сайн гэрээний дагуу ажилладаг ба цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс их, мөн ялгаварлан гадуурхалт байдаггүй байна.

- Тусгай зориулалтын тээврийн салбарт 11,500 ажлын байр байна.
- Орос, Хятадтай хиллэх хилийн 10 цэг байгаа бөгөөд 11 компани хил дамнасан тээврийн үйл ажиллагаа явуулж, 1,500 хүнийг ажлын байраар хангадаг байна.
- Улаанбаатар хотод такси үйлчилгээ эрхлэх албан ёсны зөвшөөрөл бүхий 16 компани байгаа ба нийт 12,625 орчим жолоочийг ажлын байраар хангадаг⁵³.

Жолооч болон төсөр зам, агаарын тээврийн салбарын бүх ажлын байрыг зохицой хөдөлмөр эрхэлэлт гэж үзвэл энэ салбарт нийт 67,100 орчим зохицой ажлын байр байгаа гэхэд болно.

ТЭЭВРИЙН САЛБАР ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Энэ салбарт нийт 12,506 ногоон ажлын байр байна.

4.6 БАРИЛГА

2012 онб байдлаар ДНБ-ий 2.3% орчмыг барилгын салбар бүрдүүлж байсан бөгөөд нийт ажиллах хүчиний 5.6%-ийг ажлын байраар хангаж байв.

БАРИЛГЫН САЛБАРЫН ТАЛААР БАРИМТЛАХ ТӨРИЙН БОДЛОГО

МУЗГ 100,000 орон сууц хөтөлбөр хэрэгжүүлж, жилийн 8%-ийн хүүтэй орон сууцны зээл олгож эхэлсэн нь барилгын салбарын огцом өсөлтөд нөлөөлсөн.

Барилгын салбарын огцом тэлэлт, тус салбар дахь хөрөнгө оруулалт ихээр нэмэгдсэнтэй холбогдуулан 2013 онд Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан 52/a/50/a/26/ тоот тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 4 дэх хөтөлбөрт заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, ариутгалын стандартуудын талаар тогтмол сургалт зохион байгуулах “Цэнхэр карт” санаачилгыг хэрэгжүүлж эхэлсэн.

БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР

Гүүр, усны суваг шуудуу барьж байгуулах, зам тавих нь хөрсний доройтлоос сэргийлдэг учир эдгээр үйл ажиллагааг хүрээлэн буй орчинд ээлтэй ажлын байр гэж үзэх боломжтой. Үүнд дараах ажлын байр багтана:

- Авто зам тавих: 3,286 ажлын байр

⁵⁰ Авто тээврийн үндэсний төв 2013: Статистик мэдээлэл www.teever.gov.mn/#head/statistic

⁵¹ www.teever.gov.mn/#head/үйл_ажиллагаа_зорчигч_тээвэр_хот_хааралдааны_нийтийн_зорчигч_тээврийн_ААНБ-ын_дэлгэрэнгүй_судалгаа_2013

⁵² Авто тээврийн үндэсний төв 2013: Статистик мэдээлэл www.teever.gov.mn/#head/үйлажиллагаа_зорчигч_тээвэр

⁵³ <http://www.transport.ub.gov.mn/>

- Усны суваг шуудуу барьж байгуулах: 290 ажлын байр
- Гүүр барих - 34 ажлын байр⁵⁴.

Ийнхүү нийт 3,610 ажлын байрыг хүрээлэн буй орчинд ээлтэй гэж үзэж болох хэдий ч зам тавих, барьж байгуулах шинэ тутам, экологийн цэвэр арга технологийг нэвтрүүлэх шаардлага байсаар байна. Түүнчлэн, зам тавьж дууссанаас хойш ч орон нутгийн удирдлага зам барилгын компанийдад газрын нөхөн сэргээлт хийх шаардлага тавих ёстай.

Хэдийгээр Улаанбаатар хотын захиргаа, БОНХЯны хооронд “Эрчим хүчний үр ашигтай орон сууцыг (ногоон барилга, ногоон сууц) дэмжих санхүүгийн механизмыг бүрдүүлэх, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зайд, хэмжээ MNS 5973:2009 стандартыг хэрэгжүүлэхэд 2013-2016 онд хамтран ажиллах” харилцан ойлголцлын санамж бичгийг үзэглэсэн боловч хүрээлэн буй орчинд ээлтэй барилга байгууламжийн талаар тогтсон стандарт ёнөөг хүртэл байхгүй байна.

БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Нийтдээ 69,300 орчим хүн барилгын салбарт албан болон албан бус хэлбэрээр хөдөлмөр эрхлэж байгаагийн 10,100 нь албан бус секторт байна (Хавсралт дахь Хүснэгт 5-ыг үз). Ингэснээр 59,200 ажлын байр зохистой хөдөлмөр эрхлэлтэд орох

юм. Үүнээс 31,880 хүн орон сууцны барилга дээр, 10,195 хүн инженерийн байгууламжийн барилга дээр ажилладаг бөгөөд 17,129 хүн туслах чанартай ажил хийдэг аж.

БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ НОГООН АЖЛЫН БАЙР

Онолын үүднээс хүрээлэн буй орчинд ээлтэй 3,610 ажлын байр нь зохистой хөдөлмөр эрхлэлтийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа бол ногоон ажлын байр гэж үзэх ёстай. Гэхдээ өнөөгийн байдлаар тэдний цалин хөлс, нийгмийн даатгал, хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг зохистой хөдөлмөрийн эрхлэлтийн шалгуурыг хангаж буй эсэхийг үзэхэд шаардлагатай мэдээлэл байхгүй байгаа юм. Иймд барилгын салбар дахь ногоон ажлын байрны тооцог гаргахын тулд асуудал тус бүрээр ярилцлага хийж, тоон мэдээлэл цуглуулах, баталгаажуулах зэрэг илүү гүнзгий нарийвчилсан судалгаа дахин хийх нь үр дүнтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, өмнө хийгдэж байсан судалгаа, баримт, мэдээллийг судалж үзсэний үндэснэ дээр энэ судалгаанд тавигдсан шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд өмнө дэвшүүлсэн таамаглал батлагдаагүй болно. Ажлын байрны эмзэг байдалд нөлөөлж буй бас нэг хучин зүйл нь улирлын нөлөө буюу ажилчдын ихэнх нь түр хөдөлмөрийн гэрээнд суурисан хөдөлмөр эрхлэлт эрхэлдэг явдал юм. Тиймээс эдгээр ажлын байрыг ногоон ажлын байр гэж үзээгүй болно.

⁵⁴ 2012 оны хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, YCX

5. Дүгнэлт ба цаашдын алхамууд

Хөдөлмөр эрхлэлтийн зохистой орчин нөхцөл, хөдөлмөрийн зах зээлийн зэрэг үзүүлэлтууд нь тогтвортой хөгжлийн нэгэн чухал багана болдог. Иймд ногоон ажлын байрны тухай нэгдсэн ойлголт болон улмаар Ногоон ажлын байрны тоог нэмэгдүүлэх нь урт хугацааны хөгжлийн зорилгод хүрэх үр дүнтэй стратегийн нэгэн чухал хэсэг болдог. Иймд Монголын НЭЗТТ-ийн хүрээнд Ногоон ажлын байртай холбоотой үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, тэдгээрийг үндэсний Ногоон хөгжлийн стратегитай уялдуулах нь нэн чухал юм.

Монгол Улс дахь ногоон ажлын байрны өнөөгийн нөхцөл байдал, хэтийн төлөвийг илүү нарийвчлан тодорхойлохын тулд орц, гарцын хүснэгт зэрэг судалгааны илүү нарийвчилсан арга зүй ашиглан нэмэлт судалгаа хийх нь үр дүнтэй.



Ашигласан материал

- ОУХБ 2013 “Тогтвортой хөгжил, зохистой хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байр”, V Тайлан. Олон улсын хөдөлмөрийн бага хурал, 102 дугаар хуралдаан, 2013 http://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_norm/---relconf/documents/meetingdocument/wcms_207370.pdf
- ДХБОСХ 2013 “Малайз дахь ногоон ажлын байрны судалгаа: Өмнө хийгдэж байсан судалгаанууд дээр тулгуурласан ерөнхий дүгнэлт” <http://apgreenjobs.ilo.org/project/green-jobs-malaysia/project/green-jobs-malaysia/resources/research-and-study/>
- “Эзэнтэй Монгол” Үндэсний хөтөлбөр (Монгол хэлээр)
- “Ногоон ажлын байр-Чацарагана” Үндэсний хөтөлбөр (Монгол хэлээр)
- Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих Үндэсний хөтөлбөр (Монгол хэлээр)
- “Үс” Эрчимжсэн мал аж ахуйн хөгжүүлэх тухай Үндэсний хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн газрын 2012 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр (Монгол хэлээр)
- Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам (YХААЯ) 2013: “Цаг үеийн мэдээлэл” Бюллетең #2013/04, <http://www.mofa.gov.mn/new/images/banners/report/tu04.pdf>
- YХААЯ 2013: 2007-2012 онд хамгаалагдан хөрсний үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, http://mofa.gov.mn/new/index.php?option=com_content&view=article&id=71&Itemid=155
- Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ) 2013: “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ажиллаж байгаа сэргээгдэх эрчим хүчний зарим станцууд”, www.erc.mn/mn/renewable_energy
- Монгол Улсын Их Хурал 2006: “Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого” батлах тухай тогтоолын Хавсралт 1-ийн 1.3 дахь заалт
- Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикпау үзүүлэлтийг тооцох аргачлалын талаар гаргасан YСХ-ны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хамтарсан тогтоол
- Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2012: “Хүн амын байрлал, суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа”
- М.Алтанбагана, Докторын зэрэг горилогч, YXX-ийн секторын дарга, 2012 оны 8-р сарын 28: Оролцоог урамшуулах замаар малчдыг нүүрстөрөгчийн хийг бууруулах тэмцэлд татан оролцуулья, <http://www.altanbagana44blog.spot.com/2012/08/blog-post.html#more>
- А.Бакей, Б.Чимид-Очир 2010: Малчин өрхийн амьжиргаа: Нөлөөлөгч хүчин зүйлс, сайжруулах арга зам, Хуудас 10 http://www.maas.edu.mn/index.php?option=com_content&view=article&id=310:2010-03-01-17-35-51&catid=27:2010-02-16-22-57-16&Itemid=247
- Д.Төмөрцоож 2013: Мастер судалгаа “Усны бохирдол, түүний тооцоо”
- Д.Ганбат, Отгонтэнгэр их сургуулийн багш, 2013: Япон Улстай байгуулсан чөлөөт худалдааны хэлцлийн нийгэм, эдийн засгийн үр дагавар, хуудас 23
- Дэлхийн ногоон байгаль (GWE) ТББ 2013: Шилдэг ногоон шагнал-2013, www.gwe.mn/medee/baigal-orchnii-salbariin-medee/1663-best -green-awards/2013.html
- Шатахууны мэдээллийн төв сан 2013, www.petrolium.mn/en/companys/hiin-companys/181-2011-04-12-08-45/html
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ) 2014: Монгол орны усны нөөц www.mne.mn/v3/?p=1673#UtGV-PsmWSO
- Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар 2013: Тайлан 2013, www.usug.ub.gov.mn/index.php/mega-menu/2012-07-30-0526-22/321-tailan2013
- Усны сав газрын үндэсний зөвлөлдөх уулзалт, Улаанбаатар, 2013 оны 12 дугаар сарын 18-19
- ХСУХАТАУЗЗ 2013: Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын 2012 оны балансын тэнцэл, үйл ажиллагааны тайлан, Хуудас 1, www.wsrc.mn/2013-11-12_2012onНэгтгэл.pdf
- News.mn 2012: “Хог хаягдал ангилах цэгүүдийн үйл ажиллагаатай танилц”, 2012 оны 2 дугаар сарын 29; www.news.mn/content/98670.html

- Үндэсний статистикийн хороо (YCX) 2013: 2012 оны Статистикийн жилийн тайлан
- YCX 2013: 2012 оны Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа
- YCX 2012: Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллогын үндсэн үр дүн
- YCX 2013: 2013 оны 11 дүгээр сарын Статистикийн бюллетең; www.nso.mn
- YCX 2010: 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын дүн

Цахим хуудас

- Монгол Улсын Их Хурал - <http://www.parl.gov.mn>
- Монгол Улсын Засгийн газар - <http://www.open government.mn>
- Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам - <http://www.mofa.gov.mn>
- Хөдөлмөрийн яам – <http://www.mol.gov.mn>
- Зам тээврийн яам – <http://www.mrt.gov.mn>
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам – <http://www.mne.gov.mn>
- Барилга, хот байгуулалтын яам – <http://www.mcud.gov.mn>
- Монголбанк – <http://mongolbank.mn>
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Зам тээврийн газар - <http://www.rta.gov.mn>
- Эрчим хүчний зохицуулах хороо – <http://www.erc.mn>
- Шатахууны мэдээллийн төв сан – <http://www.petroleum.mn>
- Усны үндэсний хороо – <http://www.water.mn>
- Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар – <http://www.usug.ub.gov.mn>
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл – <http://www.wsrg.mn>
- Авто тээврийн үндэсний төв – <http://www.teever.gov.mn>
- Улаанбаатар хотын захиргаа – <http://www.ub.gov.mn>
- Нийслэлийн тээврийн газар – <http://www.niityinteevэр.mn>
- Монголын хөдөө аж ахуй шинжлэх ухааны академи – <http://maas.edu.mn>
- Үндэсний статистикийн хорооны онлайн цахим сан - <http://www.nso.mn>
- Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимиын цахим мэдээллийн сан - <http://www.mongolchamber.mn>
- Дэлхийн ногоон байгаль ТББ – <http://www.gwe.mn>
- Монголын зөгийчдийн нийгэмлэг – <http://www.monapi.mn>
- Цахим сонин - <http://www.news.mn>; <http://www.mongolnews.mn>
- Олон улсын хөдөлмөрийн байгууллага – <http://www.ilo.org>
- Дэлхийн банк – <http://www.worldbank.org>

Хавсралт 1: Тоон мэдээллийн хүснэгтуүд

Хүснэгт 1: ДНБ, түүний өсөлт салбараар

САЛБАР		2008	2009	2010	2011	2012
Хөдөө аж ахуй, ой, загас агуулж	ДНБ-д эзлэх хувь	19.2	17.9	14.3	12.3	14.8
	өсөлтийн %	4.7	3.6	(-16.6)	(-0.5)	21.3
Уул уурхай	ДНБ-д эзлэх хувь	20.6	19.8	23.6	24.1	21.4
	өсөлтийн %	-1.6	5.8	3.6	7.3	8.9
Аж үйлдвэр	ДНБ-д эзлэх хувь	8.3	8.3	8.4	7.8	8.0
	өсөлтийн %	2.7	(-9)	6.1	8.3	9.7
Цахилгаан, хий, уур болон агааржуулалт	ДНБ-д эзлэх хувь	1.8	2.4	2.1	1.7	1.6
	өсөлтийн %	8.1	6.3	0.1	8.0	7.6
Усны нөөц; бохир ус, хог хаягдлын менежмент, нөхөн сэргээх үйл ажиллагаа	ДНБ-д эзлэх хувь	0.4	0.4	0.4	0.4	0.4
	өсөлтийн %	8.7	4.8	-4.0	11.4	10.0
Барилга	ДНБ-д эзлэх хувь	2.5	1.6	1.7	2.3	2.3
	өсөлтийн %	-13.8	(-34)	16.5	35.6	25.6
Тээвэр, агуулах	ДНБ-д эзлэх хувь	6.5	8.3	7.8	7.2	6.6
	өсөлтийн %	19.3	8.0	7.0	9.1	12.8
Мэдээлэл, харилцаа холбоо	ДНБ-д эзлэх хувь	3.9	3.8	3.4	3.1	3.1
	өсөлтийн %	19	7.5	6.4	5.2	19.5
Санхүү, даатгал	ДНБ-д эзлэх хувь	3.6	3.3	2.9	3.4	3.6
	өсөлтийн %	30.4	-15.6	0.3	38.5	25.7
Бусад	ДНБ-д эзлэх хувь	33.2	34.2	35.4	37.7	38.1
	өсөлтийн %	20.1	21.4	23.5	33.9	8.6
Нийт	өсөлтийн %	8.9	-1.3	6.4	17.5	12.3

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2008-2012; YCX

Хүснэгт 2: Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	2009	2010	2011	2012
15-аас дээш насны хүн ам ('000)	1 853.5	1 863.4	1 798.4	1 812.1
өөрчлөлт %		0.5	-3.5	0.8
Ажилтай ('000)	1 006.3	1 033.7	1 037.7	1 056.4
өөрчлөлт %		2.7	0.4	1.8
Хөдөлмөрийн хүчиний оролцоо, %	66.8	61.6	62.5	63.5
-Эр	61.0	67.2	68.7	69.0
-Эм	61.3	56.2	56.8	58.4
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	88.4	90.1	92.3	91.8
-Эр	88.4	89.5	91.9	91.6
-Эм	88.4	90.8	92.6	91.9
Ажилгүйдлийн түвшин, %	11.6	9.9	7.7	8.2
-Эр	11.6	10.5	8.1	8.4
-Эм	11.5	9.2	7.4	8.1
Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт цалинтай хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн %	47.4	47.5	46.5	47.8

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2012; YCX

Хүснэгт 3: Ажил олгогчид, салбараар

ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАР		2008	2009	2010	2011	2012
Хөдөө аж ахуй, ойн салбар	тоо	377.6	348.8	346.6	342.8	370.0
	өсөлт %	(-2.3)	(-7.6)	(-0.6)	(-1.1)	(7.9)
Үүл уурхай	тоо	46.5	34.8	34.1	45.1	46.7
	өсөлт %	(5.44)	(-25.2)	(-2.0)	(32.2)	(3.5)
Аж үйлдвэр	тоо	47.5	62.7	64.8	65.8	64.9
	өсөлт %	(-0.85)	(32.1)	(3.3)	(1.6)	(-1.3)
Цахилгаан, хий; уур, агааржуулалт	тоо	30.1	9.5	12.4	11.9	14.5
	өсөлт %	(-3.2)	(-68.3)	(29.9)	(-3.7)	(21.5)
Усны нөөц; бохир ус, хог хаягдлын менежмент болон нөхөн сэргээх үйл ажиллагаа	тоо		6.1	7.8	5.1	6.7
	өсөлт %		(100.0)	(27.8)	(-34.1)	(30.5)
Барилга	тоо	66.8	49.6	48.8	52.0	59.2
	өсөлт %	(114.7)	(-25.8)	(-1.7)	(6.6)	(13.9)
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	тоо	169.7	160.3	146.2	152.5	131.3
	өсөлт %	(4.6)	(-5.5)	(-8.8)	(4.3)	(-13.9)
Тээвэр, агуулахын үйлчилгээ	тоо	35.8	68.7	76.5	75.8	56.1
	өсөлт %	(10.5)	(91.8)	(11.5)	(-0.9)	(-26.0)
Харилцаа холбоо	тоо	10.5	10.2	14.5	11.5	14.7
	өсөлт %	(-3.7)	(-2.9)	(42.1)	(-20.5)	(27.5)
Санхүү, даатгалын ажиллагаа	тоо	19.8	12.3	15.2	16.6	17.4
	өсөлт %	(13.7)	(-38.1)	(23.6)	(9.4)	(4.9)
Төрийн удирдлага	тоо	50.9	65.0	70.4	64.8	76.2
	өсөлт %	(4.94)	(27.8)	(8.3)	(-8.0)	(17.6)
Бусад	тоо	186.5	178.4	196.4	193.8	198.7
	өсөлт %	(1.57)	(-4.3)	(10.1)	(-1.3)	(2.5)
Нийт	тоо	1041.7	1006.4	1033.6	1037.7	1056.4
	өсөлт %	(1.71)	(-3.4)	(2.7)	(0.4)	(1.8)

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2012; YCX

Хүснэгт 4: Албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийн тоо, 2011-2012 он, хүйс ба байршилаар

		Нийт			Байршил		
		2011	2012	/+- /	Хот суурин газар	Түүнээс Улаанбаатарт	Хөдөө орон нутагт
Нийт	Нийт	137893	174 477	+26.5	125 124	76 541	49 353
	Анхдагч	130189	164 874	+26.6	120 835	74 940	44 039
	Дам	7704	9 603	+24.6	4 289	1 601	5 314
Эр	Нийт	79776	98 175	+23.0	69 231	44 215	28 944
	Анхдагч	75809	92 373	+21.4	66 769	43 085	25 604
	Дам	3967	5 802	+46.2	2 462	1 130	3 340
Эм	Нийт	58117	76 302	+31.2	55 893	32 326	20 409
	Анхдагч	54380	72 501	+33.3	54 066	31 855	18 435
	Дам	3737	3 801	+1.7	1 827	471	1 974

Эх сурвалж: YCX, 2011-2012 оны Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

Хүснэгт 5: Албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийн тоо, эдийн засгийн ажиллагааны төрөл, хүйсээр

ЭДИЙН ЗАСГИЙН АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ	Үзүүлэлт	Он		Хүйс			
				Эр		Эм	
		2011	2012	2011	2012	2011	2012
Уул уурхай	#	6762	6134	4714	4669	2048	1465
	(+,-)		-9.3		-1.0		-28.5
Аж үйлдвэр	#	22195	27436	11282	14981	10913	12455
	(+,-)		23.6		32.8		14.1
Цахилгаан, хий; уур, агааржуулалт; Усны нөөц; бохир ус, хог хаягдлын менежмент болон нөхөн сэргээх үйл ажиллагаа	#	1402	767	972	456	430	311
	(+,-)		-45.3		-53.1		-27.7
Барилга	#	10070	10090	7154	7716	2916	2374
	(+,-)		0.2		7.9		-18.6
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	#	55010	77399	22802	32636	32208	44763
	(+,-)		40.7		43.1		39.0
Тээвэр, агуулахын үйлчилгээ	#	28308	29988	26190	28409	2118	1579
	(+,-)		5.9		8.5		-25.4
Харилцаа холбоо	#	837	1627	600	1140	237	487
	(+,-)		94.4		90.0		105.5
Санхүү, даатгалын ажиллагаа	#	170	110	54	48	116	62
	(+,-)		-35.3		-11.1		-46.6
Төрийн удирдлага	#	710	1434	280	556	430	878
	(+,-)		102.0		98.6		104.2
Бусад	#	12429	19492	5728	7564	6701	11928
	(+,-)		56.8		32.1		78.0
Нийт %	#	137893	174477	79776	98175	58117	76302
	(+,-)		26.5		23.1		31.3

Эх сурвалж: YCX, 2011-2012 оны Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

Хүснэгт 6: Албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийн тоо, ажил мэргэжлээр

АЖИЛ МЭРГЭЖИЛ	2011		2012		Өөрчлөлт %
	number	%	number	%	
Менежер	1843	1.3	3562	2.0	+0.7
Мэргэжилтэн	3257	2.4	4795	2.7	+0.3
Техникч болон туслах дэд ажилчид	1744	1.3	2174	1.2	-0.1
Контор, үйлчилгээний ажилчид	184	0.1	644	0.4	+0.3
Худалдаа, үйлчилгээний ажилчид	55050	39.9	79062	45.3	+5.4
Хөдөө аж ахуй, ой, загас агууруын мэргэшсэн ажилчид	578	0.4	903	0.5	+0.1
Үйлдвэрлэл, барилга, гар урлал болон бусад холбогдох ажил, үйлчилгээ	33629	24.4	39876	23.0	-1.4
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсралч	27999	20.3	31308	17.9	-2.4
Энгийн ажил, мэргэжил	13609	9.9	12153	7.0	-2.9
Нийт, %	137893	100	174477	100	

Эх үүсвэр: Ажиллах хүчиний судалгааны үндсэн тайллан 2012; YCX

Хүснэгт 7: Авто машины тоо, төрлөөр, ашигласан хугацаагаар

	ТӨРӨЛ	2009	2010	2011	2012	Өөрчлөлт 2012/2009	2012 %
Авто машины төрлөөр	Нийт	224 068	254 486	312 542	345 473	54.2	
	Суудлын автомашин	153 906	172 583	208 514	228 650	48.6	66.2
	Ачааны машин	47 291	61 841	75 090	83 718	77.0	24.2
	Автобус	16 136	16 366	22 547	21 642	34.1	6.3
	Тусгай зориулалтын	6 735	3 696	6 391	11 463	70.2	3.3
Ашигласан жилээр	3 жил хүртэл	14 950	8 585	10 770	20 325	36.0	5.9
	4-9 жил	24 897	54 283	46 114	79 022	217.4	22.9
	>10 жил	72 855	191 618	255 658	246 126	237.8	71.2
	>11 жил	111 366	-	-	-	-	-

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2012; YCS

Энэхүү судалгааны тайланг Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (НЭЗТТ) хөтөлбөрийн эхний үе шатны хүрээнд хийгдэх ажлын нэг хэсэг болгож бэлтгэв. Ногоон эдийн засгийн зураглалын судалгаа нь НЭЗТТ-ийн зүгээс ирээдүйд өндөр үр ач холбогдолтой байж болох үйл ажиллагаануудыг тодорхойлж, өөр хоорондоо уялдаатай нэгдсэн бодлогоор хангах нөхцөл байдлын загвар судалгаанд хувь нэмэр оруулж байгаа юм.

ЭЗБӨЧСТ-ийн зүгээс энэхүү тайланг бэлтгэхэд тоо баримт, мэдээллийн албан ёсны, үнэн бодитой эх сурвалжуудыг ашиглахыг эрмэлзэн, бүхий л боломжийг эрэлхийлэн ажилласан боловч, Ногоон ажлын байрны талаархи мэдээлэл зөвхөн энэхүү судалгаагаар хязгаарлагдахгүй. Энэхүү тайланг ашигласны улмаас үүдэн гарах аливаа хохирлыг төвийн зүгээс хууль эрх зүйн хүрээнд хариуцахгүй болно.

Түүнчлэн энэхүү тайлан нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албан ёсны байр суурийг илэрхийлээгүй бөгөөд ямарваа нэгэн хариуцлага хүлээхгүй болно.

2014 Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төв

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан.